

**ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-38
1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/	6-7
2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/	7-8
3.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлттэй танилцах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн явцын мэдээлэл сонсох	8-28
4.Улсын Их Хурлын гишүүн Б.Уянгаас үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн зардал, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийн асуудлаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад хандсан асуулгын хариуг хэлэлцэх	28-38

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны
12 дугаар сарын 23-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Б.Найдалаа ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 55.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 37 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Баясгалан, Б.Бейсен, С.Зулпхар, Б.Түвшин, Л.Энхнасан;
Чөлөөтэй: А.Ганбаатар, Т.Мөнхсайхан, М.Нарантуяа-Нара;
Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Баатархүү, Д.Батлут, Х.Болормаа, М.Энхцэцэг.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх А.Болортуяа, референт Ц.Долгормаа, Б.Цогзолбаяр, Б.Энхмаа нар байлцав.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Б.Найдалаа тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир, Д.Рэгдэл нар үг хэлэв.

Б.Найдалаа: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	3
Бүгд:	16

81.3 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Ц.Баатархүү, Ж.Галбадрах, Д.Ганмаа, Д.Бум-Очир, О.Саранчулуун, Д.Эрдэнэбат нар ажиллахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх А.Болортуяа, референт Ц.Долгормаа, Б.Цогзолбаяр, Б.Энхмаа нар байлцав.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Б.Найдалаа тогтоолын төслийн талаар танилцуулав.

Б.Найдалаа: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 4

Бүгд: 16

75.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай, Д.Бум-Очир, Д.Ганмаа, М.Ганхүлэг, Ц.Мөнхтуяа, М.Сарнай, Г.Хосбаяр, Л.Энхнасан нар ажиллахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлттэй танилцах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн явцын мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Боловсролын яамны Салбарын хяналт шинжилгээ, дотоод аудитын газрын дарга Л.Төгсбаяр, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Д.Ренчиндорж, мөн яамны Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Ю.Отгонбилэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн хэлтсийн дарга А.Хишигбаяр, Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын дарга Б.Цэцэгсайхан, мөн яамны Салбарын хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Б.Янжмаа, мөн газрын ахлах шинжээч С.Энхжин, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Д.Түмэндэмбэрэл, мөн яамны Залуучуудын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Батдорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Үнэлгээ, мониторингийн газрын зөвлөх Б.Отгонсүрэн, мөн газрын ахлах референт Б.Цэцэгмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх А.Болортуяа, референт Ц.Долгормаа, Б.Цогзолбаяр, Б.Энхмаа нар байлцав.

Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлттэй танилцах санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн явцын талаарх мэдээллийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Ж.Галбадрах, О.Саранчулуун, Д.Рэгдэл, Б.Хэрлэн нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Боловсролын яамны Салбарын хяналт шинжилгээ, дотоод аудитын газрын дарга Л.Төгсбаяр, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Ю.Отгонбилэг, Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын дарга Б.Цэцэгсайхан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Д.Түмэндэмбэрэл нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, М.Ганхүлэг, Б.Найдалаа, А.Ариунзаяа нар үг хэлэв.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Б.Найдалаа тогтоолын төслийг тараасан талаар танилцуулав.

Б.Найдалаа: “Хууль тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлттэй танилцсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 4

Бүгд: 16

75.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүд Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлттэй танилцах санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн явцын талаарх ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 16 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Улсын Их Хурлын гишүүн Б.Уянгаас үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн зардал, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийн асуудлаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад хандсан асуулгын хариуг хэлэлцэх

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, мөн газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн дарга Д.Нарансүх, Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, мөн газрын шинжээч Г.Анхбаяр, Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн газрын Хөдөлмөрийн хяналтын хэлтсийн ахлах шинжээч Ш.Хонгорзул, Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын дарга Б.Цэцэгсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх А.Болортуяа, референт Ц.Долгормаа, Б.Цогзолбаяр, Б.Энхмаа, Хяналт шалгалтын газрын ахлах мэргэжилтэн Д.Отгонбаяр нар байлцав.

Асуулгын хариуг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир танилцуулав.

Асуулгын хариутай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, О.Саранчулуун, Н.Алтаншагай, Б.Уянга, Д.Ганмаа нарын тавьсан асуултад Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн дарга Д.Нарансүх нар хариулж, тайлбар хийв.

Асуулга тавьсан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн зардал, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийн асуудлаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад хандсан асуулгын хариуг хэлэлцэв.

Уг асуудлыг 17 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 50 минут үргэлжилж, 29 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 58.6 хувийн ирцтэйгээр 17 цаг 27 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.НАЙДАЛАА

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
15 цаг 37 минут.

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Найдалаа: Сайн байцгаана уу? Гишүүдийнхээ энэ өдрийн мэндийг эрье.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны 2025 оны 12 сарын 23-ны хуралдааныг эхэлье.

Гишүүдийн ирц 55.2-оор бүрдсэн байна. Хуралдаанд хүрэлцэн ирсэн гишүүдийг танилцуулъя.

Наранцэцэгийн Алтаншагай, Дуламын Бум-Очир, Мөнгөнцогийн Ганхүлэг, Дүгэрийн Рэгдэл, Ганбатын Хосбаяр, Сүхбаатарын Эрдэнэбат, Аюушийн Ариунзаяа, Жанчивын Галбадрах, Цэндсүрэнгийн Мөнхтуяа, Отгоны Саранчулуун, Бадарчийн Хэрлэн, Отгоншарын Батнайрамдал, Даваасамбуугийн Ганмаа, Бадрахын Найдалаа, Мягмардашийн Сарнай, Доржзовдын Энхтуяа нарын гишүүд хүрэлцэн ирж, Байнгын хорооны хурал хуралдахад бэлэн болсон байна.

Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. Ирц бүрдсэн учраас өнөөдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Өнөөдөр Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал байгаа.

1 дүгээрт, Байнгын хорооны тогтоолын төсөл /Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төслийг бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Олон хүүхэд төрүүлж, өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төслийг бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

3.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлттэй танилцах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн явцын мэдээлэл сонсоно.

4 дүгээрт, Улсын Их Хурлын гишүүн Б.Уянгаас Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн зардал, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийн асуудлаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад хандсан асуулгын хариуг хэлэлцэнэ. Ийм 4 асуудал хэлэлцэх юм байна.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу?

Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэгдүгээр асуудал “Ажлын хэсэг байгуулах тухай” тогтоолын төслийг хэлэлцэж эхэлнэ.

Одоогоор ажлын хэсэгт С.Зулпхар, С.Эрдэнэбат, О.Саранчулуун, Ж.Галбадрах, Д.Ганмаа нарын гишүүд орохоор саналаа ирүүлсэн байна.

Ажлын хэсэгт нэмж орох гишүүд байгаа юу Шинжлэх ухааны? Орох тухай юу? Бум-Очир гишүүний микрофоныг нээе.

Д.Бум-Очир: Шинжлэх ухаан, технологийн хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр ажлын хэсэг байгуулах тухай асуудал тэр мөн биз Уянга гишүүн болоод Рэгдэл гишүүн, Хосбаяр гишүүн нарын? Би яг нэг зүйл тодруулж байж орох эсэхээ бас шийдмээр санагдаад байх юм. Яг энэ хуулийн төсөл дээр ажлын хэсэг байгуулах хэрэгцээ, шаардлага яг байгаа юм болов уу гэдэг дээр би жаахан эргэлзээд байх юм. Хэд хэдэн засах, сайжруулах зүйл байгаа. Тэрийг Байнгын хорооны гишүүд зарчмын зөрүүтэй санал гаргаад засчхаж болох юм шиг санагдаад байх юм.

Жишээ нь, над дээр Мандхай гишүүн бид хоёр 3 зарчмын зөрүүтэй санал бэлдчихсэн байж байна. Тэгээд явуулчихвал бараг болчихгүй юу гэсэн зүгээр бодол байна. Тэгэхээр яг ажлын хэсэг байгуулах шаардлагатай эсэх? Нэлээн тодорхой ойлгомжтой хууль гэж би ойлгоод байгаа. Хэд хэдэн засахаар асуудал байгаа. Тэр дээр маргаангүй. Жишээ нь, тэр судалгааны их сургууль гэж Ариунзаяа гишүүн бас хэлж байсан чуулган дээр тэгж оруулж болохгүй байгаад байгаа. Одоо судалгааны их сургууль бидэнд байхгүй байгаа шүү дээ албан ёсоор, хууль нь бас байхгүй байгаа гэх мэтчилний юм байгаад байгаа юм.

Тэгэхээр яг ажлын хэсэг байгуулах хэрэгцээ, шаардлага байна уу үгүй юу гэдгийг дахиад тодруулмаар л санагдаад байх юм. Зарчмын зөрүүтэй санал гаргаад Байнгын хорооны гишүүд маань асуудлаа шийдээд явчихвал илүү хялбар байх юм болов уу л гэж бодсон шүү.

Б.Найдалаа: Баярлалаа. Тэгэхээр яг энэ хуулийн төсөл дээр тов тодорхой юм шиг боловч бас худалдан авах газрын тэр хэлэлцэх эсэх дээр яригдаж байсан асуудлуудаас харахад Худалдан авах газар, Сангийн яамнаас тодорхой санал бас ирүүлээгүй байгаа. Тэгээд энийг нь Монгол Улсын хууль учраас нэгэнт хугацаа, хэлэлцүүлгийн давтамж нь таарч байгаа учраас угаасаа хаврын чуулганаар батлагдана. Тэгэхээр ажлын хэсэг байгуулан ажиллах нь илүү оновчтой гэж үзээд байгаа юм. Ажлын хэсэг дээрээ сайн тэр саналуудыг нь аваад ярилцаад тэгээд санал, дүгнэлт оруулбал илүү зөв болов уу гэж бодож байгаа.

Өөр саналтай гишүүд байгаа юу?

Рэгдэл гишүүн.

Д.Рэгдэл: Саяын Бум-Очир гишүүний саналыг хүлээж аваагүй тохиолдолд би Бум-Очир гишүүнийг ажлын хэсэгт ороосой гэж хүсэж байна. 1 дүгээрт.

2 дугаарт, Цэндийн Баатархүү гишүүн Ардчилсан нам энэ ажлын хэсэгт оръё гэж саналаа хэлсэн юм байгаа юм. Би бас тодорхой улсууд хэлсэн. Тэгээд Баатархүү гишүүнийг нэмээд оруулчих асуудал байна тэгэх үү.

Б.Найдалаа: Ойлголоо. Бум-Очир гишүүн ороход бэлэн. Бум-Очир гишүүнийг ажлын хэсгийн гишүүнд нэмье. Баатархүү гишүүн саналаа өгсөн. Баатархүү гишүүнийг бас нэмээд. Өөр саналаар нэмэгдэх гишүүд байгаа юу? Ариунзаяа гишүүн бас нэмэх юм уу? Ариунзаяа гишүүн бас нэмэгдэх юм байна.

Ингээд Зулпхар гишүүн, Эрдэнэбат гишүүн, Саранчулуун гишүүн, Галбадрах гишүүн, Ганмаа гишүүн, Бум-Очир гишүүн, Ариунзаяа гишүүн, Баатархүү гишүүн нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг болж байна.

Ахлагчаар ажиллах саналтай гишүүн байгаа. Зулпхар гишүүнээс санал ирсэн байгаа. Тэгвэл Зулпхар гишүүнээр ахлуулаад явъя.

Тэгвэл одоо “Ажлын хэсэг байгуулах тухай” тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя. Саяын бүрэлдэхүүнтэй. Зулпхар гишүүн даргалаад “Ажлын хэсэг байгуулах тухай” тогтоолын төслийг. Санал хураалтад бэлдье.

“Ажлын хэсэг байгуулах тухай” тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт.

Санал хураалтад оролцсон гишүүдийн 81.3 хувь нь дэмжиж, Ажлын хэсэг байгуулагдах тогтоол батлагдлаа.

Дараагийн асуудалдаа оръё.

15.45 цаг

Мөн **“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ.**

Энэ бол Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төслийг бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг юм.

Одоогийн байдлаар ажлын хэсэгт орохоор Ганмаа гишүүн, Саранчулуун гишүүн, Сарнай гишүүн, Энхнасан гишүүн, Мөнхтуяа нарын гишүүд саналаа өгсөн байна.

Ажлын хэсэгт нэмж орох гишүүд байгаа юу?

Хосбаяр гишүүнийг нэмье. Бас дахиад нэг эрэгтэй хүн орвол их зөв байна. Ганхүлэг гишүүн бас нэмэгдье. Бум-Очир гишүүн бас нэмэгдэх үү? Та орсон нь зөв байна. Та Бум-Очир гишүүнийг бас нэмье. Ингээд 3 эрэгтэй гишүүн нэмэгдлээ. Ингээд нэмсэн.

Ганмаа гишүүн, Саранчулуун гишүүн, Сарнай гишүүн, Энхнасан гишүүн, Мөнхтуяа гишүүн, Ганхүлэг гишүүн, Бум-Очир гишүүн, тэгээд Хосбаяр гишүүн. Эдгээр гишүүдийн бүрэлдэхүүнтэй ахлахаар нь саналаар, ахлах хүн байна уу хүсэлтэй?

Тэгвэл Саранчулуун гишүүн ахлагчтай саяын нэр дурдсан гишүүдийн бүрэлдэхүүнтэй “Ажлын хэсгийг байгуулах тухай” тогтоолын төслийг батлах санал хураалт явуулна. Санал хураалтад бэлдье.

Саяын Саранчулуун гишүүн ахлагчтай нэр бүхий гишүүдийн бүрэлдэхүүнтэй “Ажлын хэсэг байгуулах тухай” тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт.

Гишүүдийн 75 хувь нь дэмжиж, “Ажлын хэсэг байгуулах тухай” тогтоолын төсөл батлагдлаа.

15.48 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтэд танилцах санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн явцын мэдээлэл.

Байнгын хорооны тогтоолын төслийг ажлын хэсгийн ахлагч Ариунзаяа гишүүн танилцуулна. Ариунзаяа гишүүний микрофоныг.

А.Ариунзаяа: Эрхэм Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны 25 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 4 дүгээр тогтоолоор хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлттэй танилцах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан.

Тус ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа миний бие ахалж, Баатархүү, Галбадрах, Ганхүлэг, Зулпхар, Рэгдэл, Энхтуяа нар ажилласан.

Тус ажлын хэсгийн зорилго нь хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлттэй танилцаж, цаашид биелэлтийг сайжруулах талаар чиглэл, санал, дүгнэлт гаргах. Энэ хугацаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Үнэлгээ мониторингийн газар болон салбарын яамдын хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан нэгжийн албан тушаалтнуудыг оролцуулан сүүлийн 10 жилийн байдлаарх хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн бүртгэл, явцын тайлан, биелэлтийн мэдээлэл, Засгийн газраас ирүүлсэн хяналтаас хасах санал болон холбогдох 4 яамны саналыг бүрчлэн хянан үзсэн болно.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны эрхлэх асуудалд хамаарах Засгийн газар, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллага болон холбогдох бусад байгууллагад үүрэг, чиглэл болгосон нийт 37 хуулийн 259 хэсэг, заалт, Улсын Их Хурлын 13 тогтоолын 69 заалт, Байнгын хорооны 26 тогтоолын 239 заалт тус бүрийг Улсын Их Хурлын Тамгын газар Үнэлгээ мониторингийн газарт бүртгэж, хэрэгжилтэд хяналт тавьж байна.

Засгийн газраас ирүүлсэн 2025 оны эхний хагас жилийн хяналт, шинжилгээний тайлангаас үзэхэд Засгийн газар, Улсын Их Хурлын Тамгын газарт бүртгэлтэй хууль, шийдвэрийн биелэлтийг бүрэн тайлагнаагүй буюу хуулийн холбогдох заалтын 35.9 хувь, Улсын Их Хурлын тогтоолын заалтын 78.3 хувь, Байнгын хорооны тогтоолын заалтын 34.7 хувийг тус тус тайлагнасан байна.

25 оны эхний хагас жилийн байдлаар тус Байнгын хороонд хамаарах нийт 20 хуулийн 93 заалтын 31.2 хувь нь хэрэгжсэн, 60.2 хувь нь хэрэгжээгүй, 8.6 хувь нь хугацаа болоогүй, Улсын Их Хурлын 12 тогтоолын 54 заалтын 37 хувь нь л хэрэгжсэн, 55.6 хувь нь хэрэгжээгүй, 7.4 нь хугацаа болоогүй. Байнгын хорооны 20 тогтоолын 83 заалтын 57.8 хувь нь хэрэгжсэн, 36 хувь нь огт хэрэгжээгүй, 6 хувь нь хугацаа болоогүй гэж үнэлэгдсэн байсан.

Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлт хангалтгүй, биелэлтийг бүрэн тайлагнахгүй байгаа нь Улсын Их Хурлын Тамгын газар болон Засгийн газар дахь Улсын Их Хурлын шийдвэрийн бүртгэл хоорондоо зөрүүтэй, хариуцсан байгууллага биелэлтийг бүрэн тодорхой тайлагнаагүй, мөн журамд заасан үндэслэлээр буюу бүрэн хэрэгжсэн цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, тухайн шийдвэр хүчингүй болсон, тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан зэрэг үндэслэлээр холбогдох шийдвэрийг хяналтаас хасах асуудлыг огт шийдвэрлээгүй байгаагаар холбоотой байна.

Жишээлбэл, 2016 онд өгсөн үүрэг даалгавар, тогтоолын биелэлтийг 2025 онд бас тайлагнаад явж байгаа нь өөрөө бас бодит байдалд нийцэхгүй юм. Байнгын хорооноос гарсан шийдвэрийг хэрэгжүүлэгч байгууллагад тухай бүр бас хүргүүлдэггүй. Засгийн газар болон Улсын Их Хурлын Тамгын газарт бүртгэлтэй байгаа шийдвэрүүд хоорондоо зөрүүтэй байна.

Түүнчлэн гаргасан шийдвэрүүд нь хэмжигдэхүйц бус, хэт ерөнхий байдлаар гарч байгаа нь хэрэгжилтийн үр дүнг бодитой үнэлэхэд хүндрэл учруулдаг. Хэрэгжилт хангалтгүй болон хэрэгжээгүй заалтын шалтгаан, нөхцөлийг тайлагнаж, дүн шинжилгээ хийж ирүүлдэггүй зэрэг асуудлууд түгээмэл тулгарч байна.

Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлттэй холбоотой эдгээр тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор ажлын хэсэг дурдагдсан ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Нэгдүгээрх нь Байнгын хорооноос сүүлийн 10 жилд гаргасан шийдвэрийн агуулгыг хянаж, хэрэгжих боломжгүй гэж үзсэн шийдвэрийг хүчингүй болгох талаар санал, жагсаалт гаргасан. Хүчингүй болгох гэдэгтээ илүүтэй хяналтаас гаргах, цаашид үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзсэн зүйл, заалтуудын жагсаалтыг гаргасан.

Байнгын хорооны шийдвэрийн биелэлтэд үндэслэн цаашид хэрэгжүүлэх хэрэгжилтийг хянах шаардлагатай буюу хэрэгжүүлэх боломжтой жагсаалтыг бас тухайлан гаргаж эдгээр ажлуудад эрчимжүүлэх үүрэг, даалгавар болон тусгайлсан хяналтыг явуулах хэрэгтэй гэж үзсэн болно.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны эрхлэх асуудалд хамаарах хууль, Улсын Их Хурлын шийдвэр, холбогдох заалтаас бүрэн хэрэгжсэн, мөн цаг хугацааны ач холбогдолгүй болсон, хүчингүй болсон тухай асуудлаар дахин шийдвэр гаргасан үндэслэлээр 31 хуулийн 140 заалт, Улсын Их Хурлын 11

тогтоолын 28 заалт, Байнгын хорооны 19 тогтоолын 108 заалтыг хяналтаас хасах жагсаалтыг гарган 1 дүгээр хавсралтаар тогтоолоор батлах ийм жагсаалтыг гаргасан. Та бүхэнд тараасан болно.

Дээрх шийдвэрүүдийг хяналтаас хассанаар тухайн Байнгын хорооны эрхлэх асуудалд хамаарах 26 хуулийн 118, Улсын Их Хурлын 10 тогтоолын 42 заалт, Байнгын хорооны 21 тогтоолын 131 заалтын хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хангуулах хэрэгцээ, шаардлага хэвээрээ үлдэнэ.

Энэхүү шийдвэрийн талаарх мэдээллийг Засгийн газар, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагад хүргүүлснээр шийдвэрийн зөрүүтэй байдлыг арилгах, хэрэгжүүлэгч байгууллагуудын Улсын Их Хурлын шийдвэрийн талаарх бодитой, бүрэн зөв мэдээллээр хангах боломж бас бүрдэнэ гэж үзэж байгаа.

Ажлын хэсгийн удирдамжийн дагуу хийгдсэн ажлууд, тэдгээрийн үр дүнг үндэслэн Улсын Их Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг сайжруулах талаар Засгийн газар, Улсын Их Хуралд ажлаа шууд тайлагнадаг байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх Байнгын хорооны тогтоолын төслийг боловсруулсан.

Холбогдох хяналтаас бүрэн хэрэгжсэн цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон. Хүчингүй болсон тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан үндэслэлээр хяналтаас гаргах шийдвэрийг 1 дүгээр хавсралтаар, цаашид хэрэгжилтийг нь дахин эрчимжүүлэх шаардлагатай гэдэг ажлуудыг 2 дугаар хавсралтаар бэлтгэсэн.

Ингээд та бүхэндээ тогтоолын төслийг бас өнөөдөр ч гэсэн бид нар баталж болж байна. Эс бөгөөс бид нар өнөөдөр та бүхэн маань аваад, хэлэлцээд, ярилцаад хагас, бүтэн сайн өдрөөр, энэ 7 хоногтоо бас ажлуудтай танилцаад ирэх 7 хоногт бас Байнгын хороо нэгэнтээ хуралдах юм чинь бид энэ ондоо багтаагаад тогтоолын төслөө баталчих юм бол 26 оны 1 сарын 1-нээс бас өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг хянаж эхлэх тэр үнэлгээ маань илүү бодитой, илүү бодит үнэнд нийцсэн ийм үнэлгээ гарах юм болов уу гэж бодож байгаа.

Ер нь аливаа өгсөн үүрэг, даалгаврын биелэлт нь 30-хан хувь нь биелсэн. 60, 70 хувь нь огт биелээгүй байна гэдэг маань өөрөө эргээд тухайн байгууллагуудын ажлын үнэлгээнд ч гэсэн сөргөөр мэдээж нөлөөлдөг. Тэгээд энэ яагаад 60, 70 хувь нь биелэхгүй байгаа юм бэ гээд гүнзгий аваад үзэхлээр ердөөсөө 2016 оноос 2016, 17, 18 оны хүртэл үүрэг, даалгаврууд өнөөдөр биелэлтийг нь бас нэхээд үнэлгээ хийгдээд энэ бүртгэлтэй холбоотой байгаа юм.

Тэгээд яг энэ биелсэн энэ тогтоолуудыг хэн хүчингүй болгодог юм бэ гэхээр эс үгүй бол хяналтаас гаргадаг юм бэ гэхлээр үүрэг, даалгавар өгсөн субъект нь л хүчингүй, жагсаалтаас гаргах шийдвэр гаргадаг болж байгаа байхгүй юу.

Тэгэхээр Байнгын хорооноос өгсөн үүрэг, даалгавруудыг бид нар бас эндээ шууд өөрсдөө Байнгын хорооны тогтоолоор шийдвэрлэж болж байна.

Улсын Их Хурлын тогтоолоор өгсөн үүрэг, даалгавруудыг манай Байнгын хорооны хамрах асуудлын хүрээнд, харьяалах асуудлын хүрээнд хамарч байгаа

бол бид нар бас хүчингүй болгох Улсын Их Хурлын тогтоолыг бас санаачлан оруулах ийм боломжтой байгаа юм.

Тэгээд манай энэ Байнгын хорооны ажлаас хамаарч бусад Байнгын хороод ер нь Улсын Их Хурал өөрөө энэ өгч байгаа үүрэг, даалгаврууд нь бодитой, хэрэгжихүйц, цаг хугацаандаа нийцсэн байх тал дээр бас анхаарч явахгүй бол болохгүй юм байна гэдэг ийм нэгдсэн үнэлгээнд дүгнэлтэд хүрч байгаа юм. Та бүхэнд тогтоолын төсөл болон хавсралтуудыг тараасан байгаа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Ариунзаяа гишүүнд баярлалаа.

Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулж дууслаа.

Одоо Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийг танилцуулъя.

Д.Ренчиндорж Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, Ю.Отгонбилэг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга, А.Хишигбаяр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн хэлтсийн дарга, Б.Цэцэгсайхан Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын дарга, С.Энхжин Эрүүл мэндийн яамны Салбарын хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах шинжээч, Б.Янжмаа Эрүүл мэндийн яамны Салбарын хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, Д.Түмэндэмбэрэл Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга. Г.Батдорж Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Залуучуудын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга байна уу? За. Б.Отгонсүрэн Улсын Их Хурлын Тамгын газрын Үнэлгээ, мониторингийн газрын зөвлөх, Б.Цэцэгмаа Улсын Их Хурлын Тамгын газрын Үнэлгээ, мониторингийн газрын ахлах референт. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулж дууслаа.

Ажлын хэсгийн явцын мэдээлэл, Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулт асуух гишүүд нэрсээ өгөөрэй. Тусдаа.

Саранчулуун гишүүнээр тасалъя. Ирцээрээ Эрдэнэбат гишүүн асуулт асууна. Хэрлэн гишүүнийг нэмээрэй. Та анхааралтай байгаад нэрээ оруулаарай.

С.Эрдэнэбат: 2016 оноос хойш гэж ойлгосон. Үндсэндээ энэ чинь хэдэн парламент вэ 3 дахь парламент руугаа дамжсан ийм зүйл явж байгаа. Мэдээж төрийн залгамж чанар байх ёстой. Цаашдаа яг энэ Их Хурлаас гаргасан зарим тогтоолуудыг тухайн бүрэн эрхийнх нь хугацаанд нь дүгнээд нэмэлт, өөрчлөлт оруулдаг юм уу, эс үгүй бол хариуцлага тооцдог юм уу, яадаг юм, энийг нь хийе. Эс үгүй бол тэр тогтоолоо хүчинтэй болгох, болгохгүй гэдгээр нь шийдэж явах нь зөв байх гэж би бодож байна.

Энэ юутай холбоотойгоор асуугаадахъя. Идэвхтэй эрүүл мэндийн спортоор хичээллэсэн хүмүүсийг Спортыг дэмжих сангаас хөнгөлөлт үзүүлдэг болно оо гээд болсон гэдгээ тавьчихсан байна 1 дүгээрт. Тэгэхээр энэ дээр яг хэдэн хүнд яаж хөнгөлөлт үзүүлсэн юм гэдгийг нь тодруулж асуумаар байна. Мөн нийтийн биеийн

тамирыг хөгжүүлэхэд хуульд уул нь Эрүүл мэндийн даатгалын санд анхнаас ийм зүйлийг олгодог байж байгаад буцаагаад больсон.

Гэхдээ цаашдаа одоо энэ асуудал дээр дахиж бий болгоход болохгүй юм биш байгаа. Тэгэхгүй бол бид нар чинь өвчилсөн хойно л араас нь л хөөгөөд л үзээд л тэгээд л Даатгалын сан маань ч хүрэхгүй юм байна. Эмчилгээ, үйлчилгээний чанар, хүртээмж бас хүрэхгүй болоод үндсэндээ 11, 12 сард иргэд өөрсдөөсөө эм авдаг болсон байна. Он гартал ямар нэгэн мэс засал гэдэг ийм зүйлүүд ингээд хязгаарлагдсан байна. Тэгэхээр энэ Эрүүл мэндийн даатгалын тогтоолуудтай холбоотой зарим шийдвэрүүдийг бас би санаж байна.

Тэгэхээр энэ эрүүл мэндтэй холбоотой өөр бас манай Байнгын хорооноос гаргасан санал, тогтоол зүйлүүд бас бас байгаа болов уу? Тэрний хэрэгжилттэй холбоотой зүйлийг танилцсан уу, эс үгүй бол зөвхөн он хугацаагаар хассан уу гэдгийг хэлмээр байна.

Ахмад настны тухай хуулийн хэрэгжилт гээд баахан журмууд гарсан байдаг юм байна лээ. Тэгээд ахмад настанд үйлчилгээ үзүүлье гээд баахан компаниуд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой асарч, сувилах гээд л баахан компаниуд ирсэн. Тэгээд дор хаяж 1 жил ажилласан байх хэрэгтэй энэ тэр гээд ийм журмаар хаачхаад байна. Тэгэхээр юм хийе гэж байгаа хүмүүс чинь өөрсдөө алдаж онож хийж эхэлж эхлэх ёстой. Тэгэхээр 1 жил ажилласан гэхээр тэр компани 1 жил хаана юу хийх вэ тээ? Тийм учраас иймэрхүү дүрэм, журамтай холбоотой энэ хуулийг дордуулсан энэ журмуудтай холбоотой асуудлууд ер нь ямар байгаа вэ? Тэр журмуудаа шинэчлэхгүй бол зарим нь яг ажил хийхэд нэлээн төвөгтэй ийм олон журмууд бас харагдаад байдаг юм байна лээ гэдгийг хэлмээр байна.

Энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асрахад мөнгөн дүнгээ тавьсан байсан. Энэ бас их хэцүү юм байна лээ. 10 хувь өгдөг. Тэгээд 1 хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нэг ангид авчирч ирээд багш хөөрхий үйлээ үздэг. Үндсэндээ 10 хувь гэхээсээ илүү бараг тэр хүнд ялархуу юм болчихоод байдаг. Тэгэхээр энэнтэй холбоотой тогтоолын хэрэгжилттэй холбоотой тай.../минут дуусав./

Б.Найдалаа: Баярлалаа. Хариулт авахаас өмнө Ариунзаяа гишүүн та бас хариулаарай. Одоо бид нар ингээд тогтоолын төслийг батлах гэж байна шүү дээ. Яг ингээд агуулга руугаа ороод ажлын хэсгийн эцсийн санал, дүгнэлт дээр ярьж байгаа юм шиг асуудал руугаа орж ингэж ярилцах уу, эсвэл яг энэ тогтоолын төсөлтэй холбоотой тогтоолын төслөө баталж аваад ажлын хэсгээс болоогүй шүү дээ явцын мэдээлэл сонсгож байгаа. Тэгээд жоохон хязгаарлах уу гэж байгаа юм. Тэгэхгүй бол яг нөгөө асуудлаараа дамжаад ярилцаад явбал нэлээн их юм болж магадгүй. Та энэ дээр саналаа хэлээч. Тэгээд саяын асуултад бас хариулаад дээр нь нэмээд ажлын хэсгээс асууя. Хэлэлцүүлгийг яаж явуулбал зөв талаар та саналаа хэлбэл зүгээр байна. Яг тогтоолын төсөлтэй холбоотой хэлэлцүүлэг оновчтой болох юм болов уу?

А.Ариунзаяа: Манай Байнгын хорооны эрхлэх асуудалд хамаарах Засгийн газар, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллага болон холбогдох бусад байгууллагуудад үүрэг, чиглэл болгосон 37 хуулийн 259 хэсэг заалт, Улсын Их Хурлын 13 тогтоолын 69 заалт, Байнгын хорооны 26 тогтоолын 239 заалт. Нийтдээ одоо бол жил болгон бидэнд үнэлгээ мониторинг нь хийгдээд

явж байгаа. Сая бид нар өнгөрсөн жил 2 ч удаа тайланг сонслоо шүү дээ. Тэгээд аль аль тайлан дээр нь дандаа хангалтгүй буюу 30 хэдэн хувь нь л хэрэгжсэн, 60 хэдэн хувь нь хэрэгжээгүй. 7, 8 хувь нь хэрэгжих хугацаа болоогүй гэхчлэн ийм л үнэлгээ тайлан бид нарт ирдэг.

Тэгэхээр үндсэндээ яагаад энэ ажлын хэсэг байгуулагдсан бэ гэхлээр зүгээр ийм биелсэн, биелээгүй гээд зүгээр л хувь яриад байгаа нь өөрөө ямар учир шалтгааны улмаас биелэхгүй байгаа юм бэ, ямар ямар өгсөн үүрэг, даалгаврууд байгаа юм бэ гэдгийг нь агуулгаар нь харах ийм ажлын хэсэг байсан. Тэгээд агуулгаар нь хараад иртэл нээрээ л үнэхээрийн 2016 оныхаа байсан өгсөн үүрэг, даалгавар, тогтоол тухайн үедээ ач холбогдолтой байсан. Тэгээд одоо хүртэл хяналтаас гараагүй. Тэгээд ингээд л тайлагнагдаад л хэрэгжих боломжгүй гэдэг ч юм уу, эс үгүй бол хугацаа дууссан гэдэг ч юм уу тээ. Ийм байдлаар энэ үнэлгээ, мониторинг гээд ороод байгаа нь өөрөө бид нар энэ мэдээллийн сангаа ер нь цэвэрлээд, цэгцлээд авах ёстой юм байна гэдэг нэг ийм санаа байсан.

2 дахь нь болохлоор уг нь яах вэ бид нар тухайлсан сэдэв бүрээрээ бид нар энэ салбарт ийм даалгавар өгч байсан байна, энэ маань хэрэгжилт нь яаж байна вэ гэдгийг ярих нь зөв. Гэхдээ одоо яг ийм асуудлыг ярих юм бол цаг хугацаа ер нь байх боломжтой юу үгүй юу? Яг оновчтой юу үгүй юу гэдэгтэй санал нэг байна.

108 Улсын Их Хурлын тогтоолыг бид нар энд Байнгын хороогоор хүчингүй болгох боломжгүй. Хүчингүй ч гэдэг хяналтаас гаргах. 108 жагсаалтыг гаргасан 1 дүгээр хавсралт нь яг манай Байнгын хорооны тогтоолоор өгсөн үүрэг, даалгаврын 108 зүйл, заалтуудыг хяналтаас гаргая. Энэ бол 1 дүгээрт цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон байна.

2 дугаарт, шийдвэр хүчингүй болсон байна буюу тухайн Засгийн газрын буюу тухайн мөрийн хөтөлбөрийн заалттай 17, 18 оны тухайлсан даалгаврууд нь хүчингүй болсон байна. Шийдвэрт заасан хугацаа дуусгавар болсон байна. Эрх зүйн орчин шинэчлэгдсэн байна гэдэг ийм агуулгуудаар ангилаад нийт 108 зүйл, заалтыг хяналтаас хяналт энэ үнэлгээнээс гаргах нь зүйтэй байна гэж бид нар ажлын хэсгийн хувьд гаргасан байгаа.

Тэгэхээр магадгүй гишүүд маань энэ заалтыг хэвээр нь тайлагнаж явах нь зүйтэй гэж үзэж байвал уг нь энэ агуулгаар нь бид нар шинэ үүрэг, даалгавар өгч болно. Яагаад гэвэл яг энэ ажлын хэсгийн хувьд ямар учир, шалтгааны улмаас тайлагнах шаардлагагүй вэ гэж үзэж байна вэ гэдгийг яг энэ биелэлтийн тайлан гээд тусгайлсан багана гаргаад биччихсэн байгаа.

Тэгэхээр үндсэндээ яг тухайлсан 1 заалт бүр дээрээ энэ заалт яаж хэрэгжиж байна вэ гэж асуух юм бол энэ бас боломжгүй болов уу гэж бодож байна. Гэхдээ яах вэ мэдээж Улсын Их Хурлын гишүүн асуулт асуух нь бүрэн эрх л учраас яг энд байгаа спортын газраас ч гэсэн Биеийн тамирын спортын газраас төлөөлөл байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхээр Соёлын яамны төлөөлөл ч гэсэн яг энэ Улсын Их Хурлын гишүүний асуусан асуултад тухайлаад агуулгаар нь хариулж болох юм гэж үзэж байна.

Б.Найдалаа: Баярлалаа. Тэгэхээр Эрдэнэбат гишүүн асуулт асуусан. Тэгэхээр энд хариултаа бэлдэж байгаарай Соёл, спорт, аялал жуулчлалын яамныхан хаана билээ? Асуултууд ойлгомжтой тийм ээ? 7 дугаар микрофоныг нээнэ. Тэрнээс өмнө сая Ариунзаяа гишүүний хэлсэн саналын дагуу ер нь

хэдүүлээ энэ тогтоолын төслөө баталж аваад ажлын хэсгээ цааш нь шуурхайлах гээд, тодорхой болгох гээд байгаа шүү дээ. Тэгэхээр яг агуулга болгон руу ороод задлаад ярих юм бол энэ хурал нэлээн сунжраад сарних магадлалтай байна. Тэгэхээр хэдүүлээ энэ тогтоолын төсөл рүүгээ анхаараад асуудлаа угаасаа ажлын хэсгийн эцсийн санал, дүгнэлт гаргахаар тэр дээр дахиад нэг бүрчлэн яриад баталж таарна. Гишүүдэд санал байна. Та бүхэн асуулт асуух мэдээж нээлттэй. Гэхдээ тиймэрхүү байдлаар хурлаа чиглүүлээд явбал яасан юм бэ гэсэн санал байна.

Эрдэнэбат гишүүн нэгэнт асуучихсан юм чинь хариулт авна. микрофон 7.

Д.Түмэндэмбэрэл: Соёл, спорт аялал жуулчлал, залуучуудын яамнаас товчхон хариулт өгье. Спортыг дэмжих сан сүүлийн 2, 3 жилд санхүүжилт байхгүй учраас ямар нэгэн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа явагдахгүй байгаа.

Б.Найдалаа: Сая хариулт болчихсон уу? Микрофон хаагдчихав уу? Ариунзаяа гишүүнд.

А.Ариунзаяа: Би Эрдэнэбат гишүүний агуулгаар нь яг энэ заалт дээр нь юу гэж хариулах байна вэ гэхээр тухайн үедээ ЭМД-ын сангаас фитнес явах юм бол урамшуулал өгнө өө гээд цөөхөн хэдэн сар хэрэгжээд Засгийн газрын мөрийн хөтөлбөрт орсон байсан асуудал дараад нь мөрийн хөтөлбөрөөсөө бас гараад дахин хэрэгжүүлээгүй ийм асуудал байгаа.

Тэгэхээр тухайн үед хэрэгжиж байсан асуудлыг үүрэг, даалгавар болгосон нь өнөөдөр яг 25 оны хувьд үнэлгээг нь гаргаад явах нь буруу юм гэдэг л ийм агуулгаар тухайн заалт хасагдаж байгаа. Тэрнээс биш нийтийн эрүүл мэнд чухал, чухал биш гэдэг асуудал огт биш. Зүгээр тухайлсан яг энэ үүрэг, даалгавар нь ЭМД-ын сантай холбоотой спортоор хичээллэх заалт байсан. Тийм. Тэгээд Спортын хуулийг ч гэсэн өөрчлөн найруулчихсан түүнээс хойш.

Б.Найдалаа: Өөр асуулт байсан. Дараагийн асуулт нь микрофон 6.

Ю.Отгонбилэг: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Отгонбилэг. Гишүүний асуултад хариулъя. Улсын Их Хурлын Байнгын хорооны яг 22 оны 6 сарын 7-ны “Чиглэл өгөх тухай” гэсэн энэ тогтоол дээр Ахмад настны тухай болон халамжийн хуулиуд дээр энэ ахмад настны асаргаа энэ үйлчилгээний чиглэлээр ингээд хууль тогтоомжид өөрчлөлт оруулах гэсэн ийм чиглэл өгсөн байсан.

Энэ чиглэлийн дагуу 24 онд Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг Улсын Их Хурлаас дагалдах 9 хуулийн хамт баталсан байдаг. Энэ хуулийг хэрэгжүүлэх журмуудыг болон хуулиар эрх олгосны хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайд, Эрүүл мэндийн сайд хамтран асаргааны хувилбарт үйлчилгээ, идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээ гэсэн эдгээр үйлчилгээг хүргэх журмуудыг баталсан байдаг юм.

Тэгэхдээ яг энэ үйлчилгээг сонгон шалгаруулах, гэрээлэх ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, үйлч.../минут дуусав./

Б.Найдалаа: 1 минут нэмж өгье. Микрофон 6.

Ю.Отгонбилэг: Энэ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах тухай хуулийн дагуу ингэж хэрэгжүүлэхээр энэ сайд нарын тушаалд тусгасан байдаг. Эдгээр хуулиудад ерөнхий шаардлага болон чадавхын шаардлагууд гэж байгаад байдаг. Энэ дагуу яваад байгаа юм. Ер нь цаашдаа энэ нийгмийн үйлчилгээ гэдгийг ингэж бараа худалдан авахтай адилхан гэрээлэх нь ингээд өнгөрсөн жилд нэлээд их хүндрэл, ачааллууд үүсгэсэн.

1 дүгээрт, энэ тарифт үнээр тогтоод үйлчилгээ байгаа.

2 дугаарт, эдгээр үйлчилгээ нь ингээд бага үнээр ийм байхгүй тэгээд ганцхан жилийн хугацаанд гэрээлж байгаа нь энэ Худалдан авах ажиллагааны хууль нь нийгмийн үйлчилгээг гэрээлэхэд ингэж зохицохгүй байгаа ийм асуудлууд байгаа. Ийм учраас бид нар Нийгмийн халамжийн тухай хуулийг дагалдуулаад холбогдох хуулиудад бас санал гаргаад илүү энэ мэргэжлийн байгууллагуудаар хамгийн доод тал нь ядаж 3 жилээр гэрээлэх ийм чиглэлийн бас өөрчлөлтүүдийг бусад улстай адилхан контрактаа аваад гэдэг шиг ингэж хэрэгжүүлэх шаардлага үүсээд байгаа юм.

Б.Найдалаа: Баярлалаа. Эрдэнэбат гишүүн тодруулах уу болох уу? Болсон байна Галбадрах гишүүн асуулт асууна.

Ж.Галбадрах: Өдрийн мэнд хүргэе. Энэ сайн эмхэтгэл болжээ. Бид нарт бас сайхан гарын авлага болохоор болж гэж харж байна. Тэгээд 3 парламент дамжаад ирсэн тэгээд энэ дотор мэдээж Байнгын хорооны нэршлээс авхуулаад хамрах хүрээ, энэ бидний өнгөрсөн жилээс гэхэд л бид нарын чинь Байнгын хороо маань ингээд өөрчлөгдлөө шүү дээ. Тэгээд энэ нь ямар бэрхшээл авчирдаг юм, яаж ангилж энийгээ бас гаргахад нэлээн юм орсон байх гэж бодож байна. Энэ талаар бас тэр Байнгын хорооны нэршил юунууд өөрчлөгдөхөд яаж үзэж байв гэдгийг бас асууя.

Тэгээд Ариунзаяа гишүүн бас өөрөө хэлээд байна. Биелэлт хангалтгүй байгаагийн л цаад учир шалтгааныг бид нар голлон тодорхойлох зорилготой байсан гэсэн. Энэ маш сайн зорилго байна л даа. Тэгэхээр энэ дээр яг бүүр их сайхан ойлгомжтой, тодорхой жишээ байвал бас хэлж өгөөч. Ийм учир шалтгаанаас болоод энэ биелэлт хангалтгүй байдаг юм байна. Энэтэй уялдуулаад манай ажлын хэсгийнхнээс бас асуухад биелэлтийн хувь нь одоо өндөр байхын тулд Байнгын хорооны тогтоол маань өөрөө ямар байдлаар гарч байвал ер нь эхнээсээ биелэгдэхгүй ийм Байнгын хорооны тогтоол ч юм уу ийм хууль юунууд ингээд бас гараад ирдэг бол? Би яах вэ Байнгын хорооныхоо тогтоол дээр л ер нь гол төвлөрөх ийм бодолтой байна. Тэгэхээр энэ дээр юун дээр цаашид анхаарвал зүгээр байна вэ гээд. Тэгээд энэ тогтоолын төслийн 4 дээр бичсэн байна л даа энэ. Ингээд хиймэл оюун ухаан ашиглан, дүн шинжилгээ хийх гэххээд Байнгын хорооны тогтоолыг Засгийн газар болон холбогдох байгууллагад албан ёсны нэгдсэн системээр энэ шууд дамжуулан хүргэх л гэж ойлгож байгаа байх. Бид нар чинь Байнгын хорооны тогтоол маань Их Хурал руу очдог байх. Их Хурлын Тамгын газраар ороод ингээд дамжаад яваад жишээлбэл Боловсролын яаман дээр очно гэхэд бас шат дамжлага дамжаад байна уу? Шууд явдаг, дамжуулан хүргэх боломжийг судлан шийдвэрлэхийг холбогдох байгууллагад үүрэг болгосугай гэдэг нь энэ ямар байгууллагыг яамнуудыг хэлж байна уу яаж байна гэдгийг бас асуучихъя.

Тэгээд яах вэ нарийн энэ доторхоосоо л асуухыг хойш тавья гээд байх шиг байна. Тэгэхдээ би энд 1.7 гэсэн юу байгаад байна. Энд ингэж байна л даа олон улсын хөтөлбөртэй Кембрижийн “Монгол Тэмүүлэл”, “Шинэ эхлэл” гэсэн сургуулиудыг өөрийн хичээлийн байртай болгох, эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах гээд ард нь биелэлтийн тайлан дээр юу ч бичээгүй л байна л даа. Энэ тэгэхээр төсөв байсан байх гэж ойлгож байгаа тээ? Хөрөнгө оруулалтын асуудал байсан. Тэгэхээр энэ юм, энэ зүйл хаана нь тусчихсан байж байгаад энэ биелэлт бичих аргагүй ийм заалт байсан байна уу гэдгийг бас тодруулаад асуучихъя энэ дотроос.

Б.Найдалаа: Баярлалаа. Ариунзаяа гишүүн хариулна. Дараа нь Боловсролын яамнаас саяын асуултад хариулна.

А.Ариунзаяа: Манай Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээ 3 парламент дамжаад өөр өөр нэртэй байж, 2, 3-н Байнгын хороо салж нийлээд л нэгдсэн гэж ярьж байгаа шүү дээ. Тэгэхээр яг тэдгээр Байнгын хороо одоо манай Байнгын хороонд хамаарагдаж байгаа шинжлэх ухаан, соёл, спорт, залуучууд бүхий л энэ 4 салбарын хүрээнд манай энэ өмнөх байсан нэршлээрээ нэгдсэн байдлаараа ч тэр аль аль нь ороод явж байгаа. Тухайлбал, Боловсролын байнгын хорооноос өгсөн үүрэг, даалгавруудын хяналт шинжилгээ энд хийгдсэн гэсэн үг.

Ямар заалтууд нь жишээлбэл хүчингүй болж байна вэ гэхлээр 2017 оны 6 сарын 9-нд Засгийн газарт чиглэл өгсөн байгаа юм. Боловсролын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан 2017 оны намрын чуулганы хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх гээд. Тэгээд өргөн мэдүүлдгээ мэдүүлээд хууль нь батлагддагаа батлагдаад явж байтал үүнийг хяналтаас хасах шийдвэр огт гарахгүй байгаа учраас одоо хүртэл бид нар ингээд л биелчихсэн биелсэн гээд л дүгнээд явж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ өөрөө буруу юм. гэж.

Тэгэхээр ер нь энэ тогтоолын, дагаж гарч байгаа тогтоолын 4 дүгээр заалтаар хэнд үүрэг, даалгавар болгоод байгаа юм бэ гэхлээр ер нь Улсын Их Хурал өөрөө өөртөө буюу Улсын Их Хурлаас өгөгдөж байгаа үүрэг, даалгавар өөрөө системд ер нь яаж бүртгэгддэг юм? Улсын Их Хурлын тогтоол D-Parliament дээр болон legalinfo дээр гараад явж байгаа.

Байнгын хорооноос гарч байгаа тогтоол бүртгэгдэхгүй шүү дээ. Хаа нэгтээ ил тавигдахгүй тээ. Тэгэхээр Байнгын хорооноос гарсан тогтоол нь өөрөө эргээд Засгийн газар дээр хэрхэн яаж очоод яг хэрэгжүүлэх байгууллага дээрээ хэрхэн яаж очиж байгаа юм гэдэг нь ингээд дунд нь хаягдчихаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр үндсэндээ бид нар нэгэнтээ өнөөдөр энэ цахим шилжилт гэж ярьж л байгаа юм бол нэгдсэн бас ийм үүрэг, даалгаврын үүрэг даалгавар өгөлт, хэрэгжилт болоод тайлагналт нэгдсэн нэг платформтой байвал зүйтэй юм биш үү? Хооронд нь ер нь уялдуулах ёстой юм байна. Засгийн газар, Улсын Их Хурал яг энэ ажлуудаа уялдуулах ёстой юм байна. Тэгэхгүй л бол нэг нь даалгавар өгсөн болдог нэг нь тэгээд л хүсвэл тайлагначхаад, хүсэхгүй бол тэгээд мэдээгүй шүү дээ гээд л орхичихдог ийм л нөхцөл байдалтай байгаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр чанартай даалгавар өгье. Тийм, тэгээд legalinfo дээрээ ч гэсэн бас оруулдаг байя. Тэгээд ер нь бүх хэрэгжүүлэх үүрэг, даалгавар өгөгдөж байгаа газрууд нь ч гэсэн үүнийг мэдэж хэрэгжүүлдэг байя гэдэг ийм санал байгаа юм. Албан ёсны нэгдсэн системээр дамжуулан хүргэдэг, гаргадаг байна гэдэг нь

үндсэндээ legalinfo-г хэлж байгаа тээ. Болноо манай парламентын хуудаснуудыг хэлж байгаа.

Үүрэг даалгавар мэдээж нөгөө бид нар хяналт шинжилгээг тухайн үед ярьж байхад Учрал сайд байсан шиг асуугаад санаад байх юм тухайн үед яг энэ үнэлгээгээ ярьж байхад. Тэгэхэд би яг асууж байсан юм биелэгдэшгүй үүрэг даалгавар өгчихсөн байна уу? Биелэгдэх боломжгүй бол үүнийгээ Засгийн газар бас хэлэх ёстой шүү дээ гэхэд үгүй ээ бид нар гүйцэтгэх засаглал Улсын Их Хурал бидний дээд байгууллага юу ч өгсөн бай хамаагүй бид нар биелүүлэе гэхийг л хичээнэ шүү дээ гэж хариулж байсан.

Гэтэл тийм бас биш. Улсын Их Хурлыг өөрөө бас биелэгдэх боломжтой даалгавар өгч салбарыг л ажлыг нь сайжруулах гээд байгаа болохоос биш хэн нэгнийг юу гэдэг юм муухай харагдуулах, биелшгүй даалгавар өгөх нь өөрөө утгагүй шүү дээ. Тэгэхээр аль болох ажлыг нь сайжруулах, хуулийн биелэлтийг нь сайжруулах, тулгамдаж байгаа асуудал юу байна вэ гэдэг гол үндсээр нь шийдвэрлэх нь л Улсын Их Хурлын гишүүдийн, Байнгын хорооны Улсын Их Хурлын өөрийнх нь үүрэг юм гэж үзэж байгаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Галбадрах гишүүн тодруулж асуух уу? Түрүүний асуултыг түр байж байгаад Боловсролын яамнаас асууна. Түр хойшлуулаад та тодруулаад бусад саяын Ариунзаяа гишүүний хариулттай холбоотой. Галбадрах гишүүн.

Ж.Галбадрах: Харин тийм биелэгдэшгүй заалт, даалгаврыг л бид нар тогтоолоороо өгчихөөр тэгээд энэ биелэгдэхгүй юм болж байгаа болов уу гэдэг юм байгаад байгаа юм. Тэгээд бид нар чинь бас шалгуур үзүүлэлт гэдэг юм ярьж байгаа. Одоогоос нэлээн ийм, энэ чинь зүгээр ийм чанарын байдлаар биелсэн, биелээгүй, дээшилсэн, дээшлээгүй гэсэн юмнууд биччихээд байгаа бол хэдэн хувиар дээшилсэн юм, нөгөө зорилго нь хэд байсан юм, Ки Пи Ай энэ тэрийг бид нар бас оруулж ирээд явсан нь цаашид юу болох байх л даа. Үр дүнгээ өгөх байх гэж ингэж харж байгаа. Тэгэхээр тиймэрхүү Ки Пи Ай байгаагүй нөхцөлд ч гэсэн энийг бас нэлээн тодруулаад ингээд бичээд ирж.

Тэгээд бид нар энэ дээрээсээ бас цаашдаа сургамж аваад тэр юунууд ингээд оруулаад бичихэд яах вэ. Зүгээр үг хэлчхэж байгаа юм шүү Ариунзаяа гишүүний хувьд бол. Баярлалаа гээд.

Б.Найдалаа: Баярлалаа. Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: 2017 оны энэ шийдвэрийн 1.4 дээр ийм заалт орсон байгаа байхгүй юу. Тусгай хэрэгцээт боловсролын сургууль, цэцэрлэгийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны харьяалалд хууль тогтоомжид заасны дагуу яаралтай шилжүүлэх гээд. Энэнээс ургаад 5 санал байгаа юм. Тэгээд энэ 5 ажлуудаас 1 дэх нь буюу харьяанд шилжүүлээд Боловсролын хүрээлэнд шинээр Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжил, боловсрол, арга зүйн секторыг байгуулснаа татан буугдаад, дараа нь сайдын тушаалаар 23 онд ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн судалгаа, хөгжил хариуцсан эрдэм шинжилгээний ажилтныг авч ажиллуулж байна гэж байгаа юм.

Дараа нь аймаг, нийслэлийн боловсролын газар бас энэ бүтэц бий болгосон гэж байна. Ингээд хамгийн сүүлд нь энэ 5 зүйл дээр тусгай хэрэгцээт сургууль,

цэцэрлэгт ажиллаж байгаа багш, ажилтан Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар үндсэн цалингийн 10-30 хувийн нэмэгдлийг сар бүр олгож хэвшсэн гэж байна. Тэгээд 20 онд нь дахиад ердийн хэв шинжтэй цэцэрлэг, сургуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багшид бас урамшуулал нэмэгдэхээр ийм биелэлттэй гэж үзсэн байна л даа.

Гэтэл өнөөдөр яг Боловсролын яаман дээр энэ тэгш хамруулах хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын асуудал эрхэлсэн энэ бүтэц чинь яг нэг талдаа гараагүй ингээд хөдөлгөөнтэй ингээд болчихоод байгаа байхгүй юу. Яг эцсийн шийдвэр нь яахаар болсон юм бэ гэдэг дээр маргаантай асуудал үүсэж байгааг. Тэгэхээр энэ дээр би энэ яамнаас хүмүүс ирсэн байвал тодруулга бас авмаар байна. Тэгж байгаад дараа нь саналаа хэлэх бодолтой байна.

Б.Найдалаа: Боловсролын яамнаас хүн арай орж ирээгүй байх шиг байна. Түр азнаад орж ирэхээр нь саяын хариултыг авъя. Түрүүн Галбадрах гишүүний бас асуултын хариулт бас байгаа. Энэ хооронд дараагийн гишүүн асуулт асууж байх уу Саранчулуун гишүүн. Дараагийн тийм тэгье. Тэгвэл энийг түр зогсоогоод Рэгдэл гишүүн асуултаа асууя.

Д.Рэгдэл: Баярлалаа. Энэ ер нь би манай Их Хурал чинь 2 дахь удаагаа л энэ хууль тогтоолоор үүрэг, чиглэлийг болгосон Их Хурлын шийдвэрүүдийн хэрэгжилттэй танилцаад байгаа юм. Хэрэгжилт бол их муу гардаг. Ер нь дунджаар 30 хувьтай. Энэ бол янз бүрийн шалтгаантай. Сая ингээд Ариунзаяа гишүүний санаачилгаар энэ ажлын хэсэг гараад энэ манай Байнгын хороонд холбогдох шийдвэрүүдтэй ерөнхийд нь танилцсан. Түрүүчийн энэ ажлын хэсгийн хурал дээр би бас томилолттой байж байгаад оролцож чадаагүй учраас тэр үед яригдчихсан юмыг бас давхардуулбал та бүхэн уучлаарай гэж хэлээдэхье давын өмнө.

Тэгээд энд хэрэгждэггүй гэдэг дүн гардаг шалтгаанууд байна. Зүгээр яах вэ Их Хурал талаасаа, Байнгын хорооны талаас аваад харахаар энэ шийдвэрийн заалтууд нь яг чиглэл өгсөн заалт гэхээсээ илүүтэй ажлын төлөвлөгөө шиг заалтууд их өгөөд явчихдаг ийм юмнууд энэ Байнгын хорооны тогтоолуудаар тэр 2017 оноос хойш тогтоолууд байна шүү дээ. Ийм заалтууд байгаа болохоор зэрэг энэ нь нэг бол огт тасардаг, нэг бол тэгээд хаягдчихдаг ийм шалтгаан их гараад байгаа юм.

Хэт ерөнхий заалтуудыг бас оруулчихдаг чиглэл болгож чаддаггүй. Ингээд тогтмол зүгээр тухайн чиглэлээр тухайн яаманд хийдэг ажлууд, хөрөнгө оруулалтын асуудлуудыг нь чиглэл болгоод өгчихдөг энэ улсын төсвөөр батлагддаг юмыг. Энэ бүхнээс болоод биелэлт их муу гардаг юм байна. 1 дүгээрт.

2 дугаарт, энэ өмнөх шийдвэрүүдэд баахан журам гаргана гээд хуулиудад оруулаад өгчихсөн. Тэгээд нөгөө журмууд нь гардаггүй. Ялангуяа хоёр яам хамтарсан юман дээр журам ер нь бараг гардаггүй юм байна шүү дээ. Тэгээд баахан ажил хэрэгждэггүй ингээд хоцорчихдог. Одоо бид нар чинь ер нь журмынхаа тоог цөөлөөд хуулиараа л явна гэдэг ийм чиглэлтэй байгаа юм. Тэгэхээр энэ журмуудын асуудлыг ер нь бас л эргэж авч үзмээр юм шиг байгаа юм.

Энэ манай шинжлэх ухаантай холбоотой нэг тогтоол байгаа юм. Тэр 2017 оны 4 дүгээр тогтоол гээд. Тэгээд энд 10 хэдэн заалттай. Би тэрийг ингээд бүгдийг нь хараад байхад зэрэг тэр 1.8, 1.9-өөс бусдыг нь бүгдийг нь хасчихмаар байгаа

юм. Энд 3-ыг хасна гээд оруулчихсан байгаа юм. Энэ бараг 10 заалт хасаад 1.8, 1.9-ийг л үлдээгээд хяналт тавиад явж болохоор. Та бүхэн бас тэмдэглэж аваад ингээд харвал их зүгээр.

Ер нь Байнгын хороо маань шийдвэр гаргахдаа яг энэ чиглэлээр өмнө нь ямар шийдвэр гарч байсан юм гэдгийг л ямар нэг хэмжээгээр судалж үзэж байж гаргахгүй бол өмнөх шийдвэрээ харалгүй Байнгын хорооны тогтоолууд их гараад байдаг юм байна даа гэсэн ерөнхий ийм ойлголт төрсөн. Энэ Байнгын хороо энэ биелэлтэд хамгийн муу нөлөөлж байгаа юм нь юу байна вэ гэхээр зэрэг Засгийн газарт энэ.../минут дуусав./

Б.Найдалаа: Та нэмж минут авах уу? Та үг хэлж байгаад нэмээд. Рэгдэл гишүүнд нэмж минут өгье.

Д.Рэгдэл: Засгийн газарт танилцуул гээд ингээд тогтоол болгон дээр гарчихдаг хугацаа заагаад. Намрын чуулган, хаврын чуулганд гээд. Тэр танилцуулга бол ерөөсөө хийгддэггүй юм байна. Тийм учраас бид Байнгын хорооны зүгээс энэ Засгийн газарт танилцуулах хугацаа болонгуут нь ямар нэгэн дохио өгч байвал бас зүгээр байгаа юм.

Өөр нэг асуумаар юм байгаа. Одоо энэ бид нар тогтоолынхоо төслийг уул нь өнөөдөр баталчихвал их зүгээр байгаа юм энэ он дуусахаас өмнө. Энэ 5 дугаар заалт дээр би бас ойлгохгүй л байна л даа. Энэ шийдвэр бол үүрэг чиглэл болгосон шийдвэрүүд өөрөө ингээд гараад ирчихсэн байдаг. Гэтэл тэрнийг ойлгомжтой байх зарчимд нийцүүлэн үр дүнг бодитой үнэлэх боломжийг хангахад анхаарч ажиллахыг Ариунзаяа гишүүнд даалгачихсан байгаа юм. Тэгэхээр энэ чинь тэр шийдвэрийг хэмждэг, болгодог хүн нь бид нар биш шүү дээ. Цаашдын шийдвэрүүд харин хэмждэг шийдвэрүүдийг бид нар гаргаж чиглэл өгч.../минут дуусав./

Б.Найдалаа: Ариунтуяа гишүүний микрофоныг нээе.

А.Ариунзаяа: Харин тийм Рэгдэл гуай яг манай ажлын хэсгийн гишүүн учраас яг бүх асуудлуудыг мэдэж байгаа. Тэгээд ажлын хэсгийн хувьд ер нь Улсын Их Хурал болон Байнгын хорооноос гарч байгаа бүхий л тогтоолууд дээр манай л ажлын хэсэг ажиллаад байх юм уу энэ чинь нэг удаагийн энэ ажлаа хийгээд л болчихгүй юм уу. Бүхий л энэ хугацаанд манайх л хариуцаад энэ үүрэг, даалгавар хүртэл оновчтой өгөгдөхөд манай ажлын хэсэг анхаарах юм уу гэж гайхаж байгаа нь зөв өө. Тэгээд энэ дээр ч гэсэн бид нар санал нэг. Ер нь бүх энэ ажлуудыг зөвхөн манай ажлын хэсэг энэ хийнэ гэж байхгүй шүү дээ.

Манай ажлын хэсгийн үүрэг, даалгавар нь юу байх вэ гэхлээр ямар ч байсан бид нар Байнгын хорооноос өгсөн хаа байсан тэр 16, 17 оноос хойш өгч байгаа ач холбогдолгүй болсон, хяналтаас гаргах 108 ажлын жагсаалтаа гаргачихъя. Хүчингүй болгочихъя нөгөө хяналтаасаа гаргачихъя. Дараагийн үлдэж байгаа 200 тэр чинь хуулийн 118, Улсын Их Хурлын тогтоолын 42, Байнгын хорооны 131 заалтын хэрэгжилтийг цаашид хэрэгжих боломжтой, эрчимжүүлэх шаардлагатай, энэ дээр хэдүүлээ анхааръя гэдэг жагсаалтаа 2 дугаар хавсралтаараа баталчихъя.

Тэгээд дахиад манай ажлын хэсгийн нэг үлдэх даалгавар юу байх вэ гэхлээр ер нь системийнх нь хувьд яавал илүү зохистой юм бэ гэдэг дүгнэлтийг

бас хэдүүлээ гаргаад бусад Байнгын хороо болон Улсын Их Хуралдаа ер нь танилцуулчихъя. Нөхөд минь энэ чинь ийм байгаа юм байна шүү, манай Байнгын хороо ингэж үүнийгээ сангаа цэвэрлэлээ. Цаашид Байнгын хорооны тогтоол хэмжигдэхүйц байх ёстой юм байна. Тодорхой, ойлгомжтой буюу тодорхой, ойлгомжтой байх, биелэгдэх боломжтой байх энэ зарчим нийцэх ёстой юм байна. Хэрэгжилт, үр дүнг нь бодитой үнэлэх боломжоор нь бид нар хангах ёстой юм байна.

Тэгэхээр эдгээр ер нь шалгуур үзүүлэлттэй байж байж сая Улсын Их Хурлын тогтоол ч байна уу Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол ч байна уу тухайн үүрэг, даалгавар өгөгдөж байгаа байгууллагуудад их ойлгомжтой бас Ки Пи Ай гээд сая Галаа багш бас хэллээ шүү дээ. Үүнийг энэ үзүүлэлтүүдийг хангадаг байх дээр нь анхаарах ёстой юм байна, ийм ийм схемээр байвал яадаг юм гэдэг ийм л санал, дүгнэлт гаргая. л гэж байгаа юм. Тэрнээс биш бүхий л тогтоол дээр манай ажлын хэсэг ажиллана гэсэн үг бас огт биш.

Б.Найдалаа: Баярлалаа. Рэгдэл гишүүн нэмж тодруулах уу болсон уу? Минут Рэгдэл гишүүний микрофоныг нээе. 1 минут байгаа тээ?

Д.Рэгдэл: Яг тэр утгаараа энэ 5 дугаар заалт ойлгогдож байна. Тэгэхээр энийг жаахан найруулгын хувьд жаахан өөрчилчихмөөр байна. Шийдвэр гаргахдаа гэдэг, шийдвэрийг гэдэг үгийг, шийдвэр гаргахдаа гэхивэл нөгөө шийдвэр гаргах талдаа бас нэг чиглэл болгож байна гэж ойлгоод өөрчлөн найруулчихвал болж байна гэж ойлголоо. Баярлалаа.

Б.Найдалаа: Үг хэлж, санал гаргалаа. Хэрлэн гишүүн асуулт асууна.

Б.Хэрлэн: Тэгэхээр Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулаад 2 зүйлийг хөндье гэж бодож байна. Энэ тогтоолын төслийн 1 дүгээрт нь 1 дүгээр хавсралтад дурдсан Байнгын хорооны тогтоолын холбогдох заалтыг хяналтаас хассугай гэдэгтэй холбогдуулж 2 зүйл хэлэх гээд байгаа юм.

Тэгэхээр энэ Байнгын хорооны хяналтаас хасах тухай 108 ийм шийдвэр байгаа шүү дээ. Тэгээд 108 шийдвэрийн энд нэг эрүүл мэндийн салбартай, бас боловсролын салбартай 2 асуудал дээр та нарын анхаарлыг хандуулах гээд байгаа юм. Тэгэхээр цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон гэдэг үндэслэлээр 18, 19 дүгээр ажлуудыг хасах ийм санал гаргасан юм байна. Тэгэхээр энэ сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлаа, хомсдолын вирусийн халдварын тархалтыг бууруулах, хязгаарлах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай ер нь энэ талаар 18, 19 дүгээр энэ 2 шийдвэрийг хасъя гэсэн байна.

Тэгэхээр энэ дээр би юу хэлэх гээд байгаа юм бэ гэхээр 2020-оос 25 оны хөгжлийн таван жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан гээд бид нарт ирсэн. Тэгээд тэр дээр болоод ирэхээр нөхөн үржихүйн насны охид, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн дунд энэ бэлгийн замын халдварт өвчин хамгийн их байгаа. Ер нь өсөн нэмэгдээд байгаа гэсэн ийм статистик тоо орж ирж байсан л даа. Тэгэхээр энэ цаг хугацааны хувьд энэ ач холбогдолгүй болсон асуудал биш байх. Харин энэ ерөнхийдөө өнөөдөр ч хэрэгтэй анхаарал хандуулах ёстой зүйл. Энэний талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүн, биелэлтийг бид нар бас шахаж шаардах хэрэгтэй байх. Тийм учраас энэ 18, 19 хоёроо үлдээвэл ямар вэ гэж би асуух гээд байгаа юм.

Хойд талд нь 29 дүгээр ажил дээр жагсаагдсан байна. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай гээд. Тэгэхээр энийг болоод ирэхээр бас мөн цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон гэдгээр нь юм болов уу яасан юм бол. Нөгөө хасах жагсаалтад энд оруулчихсан байх шиг байх юм. Тэгээд энэ харин яг нөгөөд сургуулийн насны хүүхэд, өсвөр насны хүүхдийн хөгжлийн доройтол ер нь их байгаа яг ийм цаг үед үдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлэе, энэ үдийн хоол хөтөлбөрийг ер нь улс орон даяар ЕБС-д дунд ангийнханд өгдөг больё гэж ингэж ярьж байгаа үед энэ тухай асуудал чинь харин яг цаг хугацааныхаа хувьд хамгийн чухал анхаарал хандуулах ёстой юм биш үү? Тийм учраас энэ ажлыг бас үлдээвэл яасан юм бэ? Хасахгүй байвал яасан юм бэ гэж би асуух гээд байгаа юм.

Б.Найдалаа: Баярлалаа. Ариунзаяа гишүүн хариулна.

А.Ариунзаяа: Мэргэжлийн яамнуудаас бас нэмэлтээр хариулах байх аа. Хариулсан нь зүйтэй байх гэж бодож байна.

Тухайлсан энэ жишээлбэл энэ цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон гэж байгаа энэ 2016 оны 12 сарын 14-ний дугаар 4 энэ заалт маань Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал, хомсдолын вирусийн халдварын тархалтыг бууруулах урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай тогтоол нь жишээлбэл хүн амын дунд бэлгийн замаар дамжих халдварт өвчин нэмэгдэж байгаатай холбогдуулан аймаг, нийслэл, дүүргийн түвшинд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигтэй, ДОХ болон бэлгийн замаар дамжих халдвараас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж хэрэгжилтийг хангах гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ тухайн бодлогын баримт бичигтээ 2016 онд тусгаарай гэж байсан асуудал өнөөдөр тусгагдаад л ер нь явж байгаа шүү дээ. Нутаг дэвсгэрийнхээ хүн амын эрүүл аюулгүй, орчинд амьдрах нөхцөлийг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгаж батлуулах зарцуулалтад хяналт тавих гэж байгаа байхгүй юу. Энэ тэгэхээр их ерөнхийлөн орсон байгаа заалт байгаа байхгүй юу. Тэгээд төсөвтөө ямар ч байсан тусгаж бай, зарцуулалтдаа хяналтаа тавьж бай гээд.

Тэгэхээр энэ 2016 оны тухайн үед өгөгдсөн үүрэг, даалгаврыг яг энэ хэлбэрээр нь бид нар өнөөдөр үнэлгээ, дүгнэлтийг нь гаргаад явах нь бас өнөөдрийн түвшинд нийцэхгүй байна. Ийм учраас магадгүй эдгээр асуудлуудыг бид нар хүчингүй хяналтаас гаргаж байгаад сая яг өнөөдөр тулгамдаж байгаа юу гэдэг юм тухайн аймаг бүрийнх нь тухайлсан аль аймаг дээр нь хамгийн өндөр байгаад байгаа юм, ямар өвчлөлөөрөө байгаад байгаа юм, ямар үзүүлэлтийг хэд болгох ёстой юм цаг хугацаатай тэгээд тухайлсан илүү оновчтой үүрэг, даалгавар байх юм бол илүү зөв, зохистой байх болов уу гэсэн ийм л хандлагаар энэ цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, хяналтаас гаргая, цаашлаад үүрэг, даалгавруудыг илүү оновчтой байх тал дээр нь хэдүүлээ анхааръя гэсэн л ийм л даалгавар байгаад байгаа юм.

Б.Найдалаа: Баярлалаа. Хэрлэн гишүүн микрофон. Хэд вэ? Эрүүл мэндийн яамд микрофон 3.

Б.Цэцэгсайхан: Хэрлэн гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга

Цэцэгсайхан. Тэгэхээр Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулийн дагуу 2017 оноос хойш хөтөлбөр үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж явж байгаа. Мэдээж манайд сүүлийн жилүүдэд бэлгийн замаар дамжих халдвар, хүний дархлал, хомсдолын вирус, ДОХ-ын халдварын тохиолдол нэмэгдэж байгаа. Энэнтэй холбоотойгоор Эрүүл мэндийн сайдын бүр тусгайлсан шинэ үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдаж байгаа. Энэ дээр бэлгийн замаар дамжих халдвар, хүний дархлал, хомсдолын вирус авахаас сэргийлэх, хянах, үйл ажиллагааны төлөвлөгөөг 2025-аас 28 онд хэрэгжүүлэх ийм нарийвчилсан үйл ажиллагааны төлөвлөгөө гарч байгаа. Энд энэ асуудлууд бүүр нарийн туссан байгаа.

Б.Найдалаа: Хэрлэн гишүүн тодруулна.

Б.Хэрлэн: Тэгэхээр энэ чинь 16 оны шийдвэр. Өнөөдөр 25 он. Бид нар 20-25 оны таван жилийн хөгжлийн чиглэлийн хэрэгжилтийн тайлан, баримт бичигт өөрөөр хэлэх юм бол Эрүүл мэндийн яамнаас яг энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулаад 9 жилийн дараа гэхэд тодорхой үр дүн гараагүй энэ талын асуудал байсаар байгаад байна, бүүр өсөн нэмэгдэж байна гэсэн ийм тодорхой статистик тоонууд ороод ирсэн байгаа л даа.

Тэгэхээр өөрөөр хэлэх юм бол юу хэлэх гээд байна гэхээр та нарын авч хэрэгжүүлж байгаа энэ үйл ажиллагаа, энэ шийдвэрийн хэрэгжилт ямар байгаа юм бэ гэдгийг бид нар бодитойгоор олж хараад авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ чинь оновчтой юм байна уу, үгүй юү, үр дүнд хүрч байна уу үгүй юу гэдгийг бид нар мэдэх нь гол болохоос биш зүгээр бодлого авч хэрэгжүүлээд байгаа, сайдын тушаал гараад байгаа гэж яриад байх юм бол асуудал өшөө л цааш хурцдах байх л даа.

Б.Найдалаа: Энэ үг. Хэрлэн гишүүн үг хэллээ тийм ээ. Баярлалаа. Одоо түрүүний асуултад Боловсролын яамнаас хариулж амжаагүй байсан. Микрофон 9. Өөрийгөө танилцуулаад гишүүдийн асуултыг өгчихсөн байгаа. Хариулна уу. Микрофон 9.

Л.Төгсбаяр: Төгсбаяр Салбарын хяналт шинжилгээ, дотоод аудитын газрын дарга. Олон улсын хөтөлбөртэй сургууль гэсэн байгаа байгаа. Монгол тэмүүлэл бол байр нь баригдаад шинэ байранд орсон байгаад байгаа. Шинэ эхлэл сургуулийг СХД-т барихаар төсөв дээр мөнгө нь ороод ингээд явж байгаа.

Дараагийнх нь тусгай хэрэгцээт боловсролын сургууль, цэцэрлэг гээд тусгай хэрэгцээтэй холбогдуулж бас асуулт асуусан байна. Энэ дээр манайх яаман дээр болон Боловсролын ерөнхий газар бол Тэгш хамрах хэлтэс байгуулагдаад ажиллаж байгаа. Мөн хуулиудад зохих хуулиуд дээр бас асуудлуудаа ингээд тусгаад ингээд явж байгаа. Ингээд товчхон хариулъя.

Б.Найдалаа: Саранчулуун гишүүний хариулт. Микрофон 9.

Л.Төгсбаяр: Ямар асуулт байсан? Уучлаарай.

Б.Найдалаа: Хариулт болчхож байгаа юм уу?

Саранчулуун гишүүн нэмж тодруулж асуух уу? Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Байж байгаарай асуудлуудаа ингээд хуулиараа хэлэлцээд явж байгаа гэдэг чинь юу гэсэн үг билээ? Анхан тэгэхлээр хүүхдүүд тэгш хамран сургах энэ хуулиар олгогдсон эрх, сурах эрх нь зөрчигдөж байна гэдэг энэ асуудал гараад. Яагаад гэхлээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нэг хаяг дээр бүртгүүлдэг. Тэр бүртгүүлсэн хаягаа систем дээрээ солих боломжгүй ийм нөхцөл үүсчхээд байгаа. 1 дүгээрт.

2 дугаарт гэвэл бүх хүүхдүүдийг сурах боломжтой гэсэн мөртөө тухайн нөгөө бүртгэлтэй хаяг дээр байгаа бага, дунд сургууль руу хүүхдүүд сурах гээд очихоор тэнд нь нөгөө хүүхдийг хүлээж авах орчны болон багшийн заах арга зүйн бэлтгэл хангагдаагүйн улмаас энэ хүүхдийг манай сургууль авах боломжгүй байна гэдэг ийм хариу өгөөд байгаа юм. Тэгэхээр нөгөө эцэг, эх яаж байгаа вэ гэхээр боломжтой тойрогтой, боломжтой газар руу нь явж очоод хүүхдээ сургая гэхээр хамран сургах тойргийн харьяалал биш байна, эсвэл бүртгэлгүй байна гэдэг асуудал гарч ирчхээд байгаа байхгүй юу.

Нөгөө талд за тэгвэл хүүхэд авах боломжгүй юм байна, бэрхшээлийн хүнд, хөнгөнөөс хамаараад бас асуудалтай байгаа тохиолдолд дэмжих төв гэдэг шийдлүүдийг энэнээс хойш ярьсан байгаа. Тэгэнгүүт дэмжих төв дээр одоо нэмэлтээр сургалт, мэргэжлийнхэн хөдөлгөөн засалч байдаг юм уу ингээд ажиллаад хүүхдүүдийг сургах гэхээр дэмжих төвийн зардал дээр асуудал үүсэж байгаа юм.

Тэгэхээр сургууль тэгш хамруулан сургахтай холбоотой зардлыг сургууль, цэцэрлэг бол улсынх нь аваад, бид нар энэ харьяалалд байгаа бүртгэлд энэ хүүхдүүдийг сургая гэж авчхаад сургаж чадахгүй байгаа бол тэр зардлыг нөгөө ойр хавьд байгаа дэмжих төв рүү нь хүргүүлж өгчих ийм асуудлыг л өмнөх сайд нар, яамнууд ярьж байсан юм байна лээ л дээ тушаал энэ асуудлаар.

Гэтэл тэр нь ингээд зогсонги байдалд орчихсон байгаа байхгүй юу. Үүгээр маш олон эцэг эхчүүд асуудлаа яриад яг үнэндээ энэ дээр байгаа ажил чинь биелэгдэхгүй байна шүү дээ. Энийг нэг тийш болгоод өгөөч гэдэг ийм гомдол, саналууд над дээр ирсэн юм.

Тийм учраас би энэ 27 онд ярьсан Засгийн газрын хүүхдүүд сурч байгаа шүү дээ, болж байгаа гэдэг энэ биелэлтийг дутуу байна, процессын хувьд алдаатай юм болсоор байгаа шүү гэдэг нэг асуудал.

2 дугаарт, энэ асуудлаарх тэр бодлого, хэрэгжилтийг хариуцдаг тэр Боловсролын ерөнхий газар дээрх нэгж, яаман дээрх хэлтэс энэ тэрийн чинь асуудлууд ямар түвшинд байгаа юм бэ? Энийгээ тэгээд цааш нь яах вэ гэдгийг тодруулж асуугаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр надад тодорхой хариултууд өгнө үү.

Б.Найдалаа: Микрофон 9.

Л.Төгсбаяр: Бүтцээрээ аймгийн болон дүүргүүдийн боловсролын хэлтсүүдэд бүүр тусгайлан орон тоо баталж өгсөн байгаад байгаа. Тэгээд хүүхдийн хөгжил, хамгаалал, тэгш хамран сургах боловсрол хариуцсан арга зүйч нар бас ингээд албан тушаалыг нь баталж өгөөд ингээд хэрэгжүүлж ажиллаж байгаа.

Б.Найдалаа: Саранчулуун гишүүн хариулт хангалттай юу? Тодруулж асуух 1 минут байна.

О.Саранчулуун: Яах вэ дээ надад хариулахгүй юм байна шүү дээ ерөөсөө. Би асуугаагүй байхгүй юу. Энийг чинь ингээд хүүхдүүдийн сургуульд, хүүхдээ хаана аваачиж сургах вэ гээд хүмүүс асуугаад байна шүү дээ. Тэгээд орон нутагт бүр хэцүү байна. Улаанбаатар хотод ирээд сургах гэхлээр сургууль, цэцэрлэг тэр мөнгөө шилжүүлэхтэй холбоотой 1 удаагийн тушаал, сайдын захирамж энэ тэр гарсан байгаа шүү дээ. Тэрний чинь залгамж холбоо болохгүй байгаа байхгүй юу. 2017 онд эхэлсэн энэ ажил л чинь өнөөдөр 2025 он гэдэг чинь ингээд дундаа ингээд тасалдаад байгаа байхгүй юу. Яаж тайлбарлавал ойлгох юм процессын хувьд тасалдаад байна шүү дээ. Тэгэхээр энийг ингээд биелчихсэн, болчихсон гэж үзэх нь зөв юм уу гэдэг асуудал байна. Дээрээс нь танай яам энэ дээр аль талдаа гарч байгаа юм бэ? Тэр хүүхдүүдийн хаягийг яаж байгаа юм, тэгш хамруулахыг яаж байгаа юм? Мэргэжилтэн бэлдчихсэн гэдэг чинь хүүхдүүд сурч байгаа гэсэн үг биш биз биз дээ?

Б.Найдалаа: 9 номер Боловсролын яамнаас хариулах хариулт байгаа юу? Өмнөх шигээ байх юм уу? Юм байхгүй бол бас байхгүй байж болно. 9 номер.

Л.Төгсбаяр: Ер нь яг хүүхдүүдийг яг харьяа газруудад нь ав гэдэг чиглэл өгөөд явж байгаа. Яг тэгэхдээ энэ дээр ганц багш, боловсон хүчнээс гадна хүүхдүүдийн бас хандлага юмнаас бас шалтгаалаад тухайн хүүхдүүд бас энэ сургуульд сурахгүй, эцэг, эхчүүд нь хүүхдүүдээ энэ сургуулиас шилжүүлбэ гэдэг бас асуудлууд мэр сэр тавьдаг. Тэгэхдээ яамны зүгээс яг боловсон хүчин бэлдэх, орон тоо юмнуудыг нь бэлдээд энэ дээр анхаарч ажиллаж байгаа.

Б.Найдалаа: Ингэе дээ. Өнөөдөр Боловсролын яамнаас яг оролцоо, төлөөлөл хариулт хангалтгүй байна. Саранчулуун гишүүний асуултад ер нь хариулт байхгүй байна. Тэгэхээр та очиж байгаад Төрийн нарийндаа хэлж байгаад яг энэ асуултыг тэмдэглээд авсан байх. Хэрэгтэй бол манай энэ референтүүдээс аваарай. Бичгээр Саранчулуун гишүүнд хариулт ирүүлээрэй.

Гишүүд асуулт тавьж, хариулт авч дууслаа.

Одоо ажлын хэсгийн явцын мэдээлэл болон тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрсээ оруулъя.

Саранчулуун гишүүнээр хаалаа. 2 гишүүн байна. Ганхүлэг гишүүн. Ирцээрээ дараалалд нь оруулчхаж. Уучлаарай Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Бүгдээрээ улсаараа ингээд хийж ер нь смарт зорилго гэдэг юмаа л суръя даа. Ингээд бүх юманд аймаар супер супер олон улсын элдэв янзын юм ярьж ингээд шинээр юм хийх гэж байснаас зүгээр л смарт буюу хэмжигдэх боломжтой, хүрэх боломжтой, цаг хугацаатай төлөвлөгөө гаргаж суръя. Тэрнийхээ дагуу тэрийгээ хийдэг л болчихвол болох гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр 1 дүгээрт.

Хоёрт гэвэл энэ тогтоол дээр байгаа 1 дүгээр хавсралтад дурдсан энэ заалтыг хяналтаас хассугай гэж байна. Би бусдыг нь судалж харж амжаагүй учраас яг энэ дурдаад байгаа энэ 2017 оны 1.4-ийг эндээс хойших бусад асуудалтай нийлүүлэн араас нь үргэлжлүүлж нэг талд нь гаргах ийм саналтай

байгаа учраас энэ бүрийг хасах, ийм үргэлжлүүлэн анхаарах хэсэг рүү нь оруулах бодолтой байна.

Өөрөөр хэлбэл, 2 дугаар хавсралт руу шилжүүлэх ийм саналтай байна. Баярлалаа.

Б.Найдалаа: Үг хэлж байгаа юмыг чинь Ариунзаяа гишүүн дараа нь яачихъя тэгэх үү? Тэгье. Ганхүлэг гишүүн.

М.Ганхүлэг: Баярлалаа. Миний бие бас ажлын хэсэгт орж ажилласан гишүүдийн нэг байгаа. Энэ бас бусад Байнгын хороо ер нь Улсын Их Хурлын гол бас чиг үүрэг болсон хяналт шалгалт явуулахтай холбогдолтой асуудлыг бас цогцоор нь харах ийм хэрэгцээ байгааг харуулсан ийм ажлын хэсэг болсон.

Ажлын хэсэг бас нэлээн богино хугацаанд идэвхтэй бас ажилласныг би бас энд цохож хэлье. Сүүлийн 10 жилийн хугацаанд бас хийсэн ажлуудыг бүгдийг нь бас гаргаж ирээд ингээд ярилцсан. Бусад Байнгын хороонууд бас мөн бас тодорхой энэ жишгийн дагуу ажиллаад явах нөхцөл, боломжууд бас бүрдээд явна гэж ойлгож байгаа.

Тэгэхээр тогтоолын төсөлтэй холбогдолтой, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээтэй холбогдолтой ер нь бидний гол үндсэн 2 чиг үүрэг байгаа. Парламент болон Байнгын хороо тодорхой бас энэ нийгмийн харилцааг зохицуулах хууль, эрх зүйн орчныг санаачилж батлах үндсэн ийм чиг үүрэг байгаа. Үүний хүрээнд үндсэндээ ажлуудаа хийгээд тодорхой чиглэлүүдээ өгөөд явж байна.

Хоёрт нь батлагдсан энэ хууль тогтоомж, түүнтэй холбогдолтой асуудлууд хэрхэн хэрэг ж байна вэ гэдэг дээр бид бүхэн бас дүгнэлтээ өгөөд явах үндсэн ийм 2 чиг үүрэг байгаа. Энэ хүрээнд үндсэндээ бид нар ажлын хэсгийн зөвхөн дүгнэлт, санал гэхээс гадна нэлээн асуудлыг өргөн хүрээнд авч хэлэлцэх ёстой юм байна гэсэн зүйл бас яригдсан. Ялангуяа Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль тодорхой асуудлыг зохицуулж байгаа. Тэгэхдээ энэхүү бас хуулийн хэрэгжилт, энэ агуулгыг ажлын хэсэг байгуулж байж байдаг юм уу, тодорхой ийм анхаарал хандуулж байж цаашдаа бас авч хэлэлцдэг, дүгнэлтүүд гардаг ийм зохицуулалтууд бас байлгүйгээр сууриар нь яаж зөв явах энэ механизмыг бий болгох вэ гэдэг дээр бас тодорхой санал, дүгнэлтүүд бас чиглэж гарах нь зөв юм байна гэсэн ийм саналтай байгаа. Жил болгон тодорхой тайлагнадаг хугацаа, чиг үүргүүдийн энэ байдлуудыг нь бас олон нийт мэддэг, түүн дээрээ хяналт тавиад явдаг ийм байх хэрэгцээтэй байгаа юм.

Тийм учраас тодорхой энэ бас ганц нэгэн бас саналуудыг илүү нарийвчилж бас оруулах нь зөв болов уу гэсэн ийм саналтай байгаа байгаа. Жишээлбэл, Монгол Улсын Их Хурлын гишүүн хууль санаачлах энэ бас боломжоо D-Parliament-аар бас дамжуулж иргэд, олон нийтийг нээлттэй оролцуулдаг ийм бас хэлбэртэй болгосон. Энэ бас өмнөх парламентын хувьд маш чухал санал, санаачилга байсан. Эгэл жирийн иргэд, олон нийт явж байгаа энэ хууль тогтоомж дээр цахим энэ дэвшилтэт технологийг ашиглаад саналаа өгдөг ийм механизм бүрнээ хэрэгжээд бас ингээд явж байгаа.

Тэгээд яг үүнтэй адилхан олон нийт хяналт тавихад хэрхэн ер нь оролцож болох вэ? Энэ гарч байгаа хууль тогтоомжийн хэрэгжилт дээр тодорхой бас өөрийнхөө санал, сэтгэгдлийг бас оруулаад явах дээр бид бүхэн цаашдаа бас

ямар үр дүн гаргаж болох вэ гэдэг рүү манай энэ тогтоолын төсөл илүү бас чиглээд энэ ч чиглэлийн асуудал зөвхөн манай Байнгын хороо биш ингээд ороод явах ёстой суурь асуудлыг нь шийдчих нь зөв байгаад байгаа юм.

Энэ утгаараа нэгд бас энэ ди-хяналт гэдэг юм уу, илүүтэй энэ олон нийтэд нээлттэйгээр энийгээ харуулдаг, тэр дээр нь санал, дүгнэлтээ бас өгдөг ийм механизмыг оруулаад бас өгөх талаас нь ер нь бид нар, бид бүхэн бас судалж ажил хэрэг болгох нь зөв юм гэсэн эхний санал байгаа юм.

2 дахь нь одоо бид нарын энэ шалгуур үзүүлэлтүүд тавиад дараа дараагийнхаа сайжруулах нэг асуудал байгаа.

Нөгөө талаасаа нэгэнтээ хийгдсэн байгаа энэ үр дүнг үр дүнтэй болсон, болоогүйг яг хэн дүгнэж байна вэ гэдэг дээр бас жоохон бид нар анхаарал хандуулах хэрэгтэй байгаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр яг тухайн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг арга хэмжээ зохион байгуулсан яам, тухайн агентлагаас гадна яг хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь өөрсдөө яг юу гэж дүгнэж байгаа вэ гэдгийг бид бүхэн бас анхаарч үзмээр. Тэгэхээр энэ олон нийтийн нээлттэйгээр хяналт шалгалтад оролцох энэ боломжийг бас олгох чиглэлийн асуудлууд дээр цаашдаа бас анхаарал хандуулах энэ заалтуудыг ерөнхий агуулгаар нь оруулчихсан байгаа, илүү детальчлаад бас хэрвээ өнөөдөр бас батлахгүй бол оруулаад явбал ямар вэ гэсэн ийм бас саналтай байгаа юм.

Б.Найдалаа: Баярлалаа. Би гишүүнийхээ хувьд үг хэлье.

Юуны өмнө яг энэ ажлын хэсэгт орж ажилласан гишүүд болон ажлын хэсгийн ахлагч Ариунзаяа гишүүнд бас баяр хүргэмээр байна. Энэ үнэхээр онцгой, чухал ажлын хэсэг. Тэгээд өдийг болтол маш богино хугацаанд бас үр дүнтэй ажилласан байна. Зөвхөн энэ хууль тогтоомж ч биш ер нь хуулийн хэлэлцүүлэг дээр хүртэл анзаарахад Их Хурал, гишүүд өөрсдөө Байнгын хороо асуудалд бас хэрэгжих эсэх дээр нь анхаарахгүйгээр хүслийн жагсаалт маягийн шийдвэр гаргах хандлага их байна.

Нөгөө талаасаа бас онцгой зүйл бол Засгийн газар, чиглэлийн яамд өөрсдөө зөв, буруу гэдэг дээр байр суурь байгаа хэр нь тэрийгээ зоригтой илэрхийлэхгүй, эс үйлдэл гаргаад ч юм уу, чанаргүй шийдвэр гаргахад нөлөөлж байна гэж үзэж байна. Тэгэхээр яг түрүүн Ариунзаяа гишүүнд дурдаад байсан засаг өөрөө бас, Засгийн газраас бас үгүй гэх газраа үгүй гэдэг, болохгүй газар нь болохгүй гэж хэлдэг, Байнгын хороо, Их Хурал хүртэл бас яг энэ дээрээ хэрэгжих бодитой эсэх, хэрэгтэй эсэх дээр бас дүгнэлт хийдэг байх нь зайлшгүй байна. Тэгэхээр энэ ажлын хэсгийн үр дүнд яг эдгээр асуудлуудыг цаашид Улсын Их Хурлын дэгийн тухай хууль, эсвэл Хууль тогтоомжийн тухай хуульд өөрчлөлт оруулах болзошгүй нэмэлт, өөрчлөлт оруулах, оруулж шийдэх ч юм уу ийм шийдлүүд гарч ирэхээр байгаад байгаа юм.

Тэгээд энэ тогтоолын төслийг Ариунзаяа гишүүн түрүүн дурдаад байна. Дараагийн 7 хоногт болсон ч болно оо гэж байна. Зүгээр гишүүдийн саяын хэлж байгаа үг, саналыг харгалзвал, мөн тогтоолын төсөл дээр ажлын хэсэг болон Байнгын хорооны зөвлөхүүд нэлээн сайн ажиллачихсан байгаа. Тэгээд гаргаж байгаа илүү тийм зарчмын зөрүүтэй санал байхгүй байна. Зөвхөн найруулгын, редакцын чанартай саналууд байна. Эдгээр саналуудыг нь тусгаад өнөөдөр хэдүүлээ цаг алдахгүй батлаад явбал илүү үр дүнтэй санагдаж байна.

Тогтоол дээр та бүхэн анзаарч байгаа бол энэ тогтоол, шийдвэрүүдийг 3 ангилчихсан байгаад байгаа юм. Нэг нь аль хэдийн биелчихсэн, эсвэл цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон. Эдгээрийг хяналтаас гаргаад хасчхаж байна.

Нөгөө талаасаа Байнгын хорооноос хамааралгүйгээр хууль болон Улсын Их Хурлын тогтоолоор өгсөн шийдвэрүүдийг хэрхэх талаар бас санал, дүгнэлт гаргах юм байна.

Нөгөө талаасаа яг жинхэнэ хяналт хэрэгжүүлэх ёстой нь яг бид нарын Байнгын хорооны өөрсдийн гаргасан тогтоол, шийдвэрүүд байгаа. Тэгээд иймэрхүү цэгцтэй ангилчихсан болохоор цаг алдахгүйгээр энийг тогтоолоо батлаад ажлын хэсгийн дараагийнх нь шатын ажилд оруулъя гэсэн саналтай байна.

Ингээд Ариунзаяа гишүүн үг авмаар байгаа юм уу? Тэгвэл ажлын хэсгийн ахлагч миний дараа Ариунзаяа гишүүнд үг нэмж өгье. Тэгээд түүний дараа хэдүүлээ тогтоолын төслөө батлах санал хураалт явуулъя.

Ариунзаяа гишүүний микрофоныг нээе.

А.Ариунзаяа: Тийм санал хэлж байгаа, асуулт асууж байгаа, үг хэлж байгаа бүх гишүүдэд баярлалаа. Би Саранчулуун гишүүний санаа тавиад байгаа юманд бүрэн хүлээн зөвшөөрч байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг бүрэн сургалтад хамруулах нь өөрөө Боловсролын яамны чиг үүрэг мөн. Бид үүнд бас хяналт тавих ёстой.

Гагцхүү энэ яригдаад байгаа 2017 оны 6 сарын 9-ний 24 тоот чиглэл нь өөрөө тусгай хэрэгцээт боловсролын сургууль, цэцэрлэгийг БСШУСЯ-ны харьяанд хууль тогтоомжид заасны дагуу шилжүүлэх, энэ асуудлыг хариуцсан орон тоог бий болгох гэх зэрэг асуудлууд нь өнөөдөр хүүхдүүд сурч чадаж байна уу үгүй юү гэдэг асуудал огт биш байхгүй юу. Тэгэхээр ийм учраас ажлын хэсгийн зүгээс энэ үүрэг, даалгаврыг цаг хугацаандаа болоод тухайн хуулийн шинэчлэл болон орон тоо болон бусад чиг үүргүүдээ хангачихжээ.

Харин өөр асуудлууд байгаа бол ёстой жинхэнэ смарт хэд байгааг хэд болгох ёстой юм. Заавал хамран сургах тэр хаягаараа байх ёстой юм уу үгүй юм уу гэдэг илүү оновчтой өнөө цагийн үүрэг, даалгавар өгөх нь харин эсрэгээрээ нээлттэй байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ 17 оныхыг хэвээрээ байлгана гэж зуурах хэрэггүй. Энэ тогтоолыг хүчингүй болгосноороо бид нар энэ асуудалд анхаарахаа больж байгаа асуудал огтоос биш. Тэгэхээр энэ энэ өнцгөөс нь харж гишүүд маань өнөөдөр энэ тогтоолын төслийг батлаад өгчихвөл бас дараа дараагийн ажилд бас илүү хэрэгтэй байх юм болов уу гэсэн ийм саналтай байна. Баярлалаа.

Б.Найдалаа: Ажлын хэсгийн явцын мэдээлэл тогтоолын төсөлтэй холбогдуулан гишүүд үг гэж дууслаа.

Та бүхэнд танилцуулсан байгаа. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын төсөл, “Хууль тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлттэй танилцсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” тогтоолын төсөл та бүхэнд хүргэгдсэн байгаа.

Тэгэхээр энэ тогтоолын төслийг түрүүн хэлсэн гишүүдийн зарим санал, найруулгын чанартай, редакцын чанартай засваруудыг оруулаад тэгээд батлаад явъя гэсэн томъёоллоор санал хураана. Санал хураалтад бэлдье. Хэрлэн гишүүн ороогүй байна даа. Эрдэнэбат гишүүн.

Тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт.

Гишүүдийн 75 хувийн саналаар тогтоолын төсөл батлагдлаа.

Ажлын хэсгийн ажилд амжилт хүсье.

16.55 цаг

Дараагийн асуудалд оръё.

Улсын Их Хурлын гишүүн Б.Уянгаас Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн зардал, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийн асуудлаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдад хандсан асуулгын хариуг хэлэлцэх юм.

Асуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайд Аубакир танилцуулга хийнэ. Аубакир сайдыг микрофонд урьж байна.

Т.Аубакир: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Б.Уянгаас 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 48 дугаар албан бичгээр ирүүлсэн асуулгад дараах тайлбарыг өгч байна.

2024 оноос хэрэгжиж эхэлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 13.2 дахь хэсэгт урьдчилсан сэргийлэх арга хэмжээний зардлын төлбөр нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн тухайн жилийн шимтгэлийн орлогын орлогын 2 хувиас багагүй байна гэж заасан.

Үүний дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 7 дугаар сарын тогтоолоор үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх, хяналт тавих журмыг баталсан.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан 64 арга хэмжээнээс 44 арга хэмжээг зохион байгуулсан. 2024 онд 26 арга хэмжээнээс 2 арга хэмжээг хэрэгжүүлсэн. Харин 2025 онд 62 арга хэмжээ төлөвлөснөөс 42 арга хэмжээг хэрэгжүүлээд байна. Харин 2023 онд үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн тоо 903, мөн 2024 онд 922 байгаа нь өмнөх оны жилийн эцсээс 2.1 хувиар өссөн байна.

Цаашид ажил олгогч даатгуулагчийн хөдөлмөрийн эрүүл ахуй, эрүүл мэндийн үзлэг, тандалт, ажил мэргэжлийн тохироо, сэргээн засах тусламж, үйлчилгээний талаарх зохицуулалтыг олон улсын конвенц хэм хэмжээнд нийцүүлэн сайжруулж, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт илрүүлэх, хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх үр нөлөөг нэмэгдүүлэх, хөдөлмөр, аюулгүй байдал, эрүүл мэндэд тавигдах шаардлагыг тодорхой болгож, өндөрт ажиллах аюулгүй ажиллагаа, хязгаарлагдмал орчин, хими, биологи, эргономик, нийгэм, сэтгэл зүйн хүчин зүйлс зэрэг асуудлаар шинээр зохицуулахаар Хөдөлмөр, аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгаад байна.

Б.Найдалаа: Дууссан уу сайд? Баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя. Б.Батжаргал Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Д.Нарансүх Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн дарга, Ц.Ганцэцэг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлого хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга, Г.Анхбаяр Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын шинжээч, Ш.Хонгорзул Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн газрын Хөдөлмөрийн хяналтын хэлтсийн ахлах шинжээч, Цэцэгсайхан Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын дарга.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулж дууслаа. Дэгийн тухай хуулийг сануулъя. Энэ дээр гишүүд 3 минутаас илүүгүй хугацаанд асуулт асуух гэж заасан байгаа. Тэгээд 3 минут өгөгдөнө.

Танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ оруулъя.

Саранчулуун гишүүнээр тасаллаа. Ариунзаяа гишүүнээс эхэлнэ.

А.Ариунзаяа: Би Аубакир сайд болон нийгмийн даатгалынхан маань байгаа дээр яг энэ сангийн бүрдүүлэлт хэр байна вэ? Яг мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр, тэтгэмжийн сангийн нөхцөл байдал ямар байна вэ гэдэг нэг асуулт.

Хоёр дахь нь болохлоор хуулиар хүлээсэн үүргээ байгууллагууд хүлээхгүй байгаатай холбоотой Засгийн газар ямар нэгэн хэрэгжүүлж байгаа ажил байна уу?

Гурав дахь нь болохлоор нэгэнтээ л сангийн талаар асууж байгаа юм чинь энэ ажилгүйдлийн тэтгэмжтэй холбоотой маш олон иргэд тэтгэмжээ авч чадахгүй байна гэдэг ийм асуудлыг яриад байна. Энэ 2 юман дээр л бас ялгаж зааглах ёстой. Нэг нь болохлоор төрийн албан хаагч цомхотголоор, эсвэл байгууллагад ажиллаж байсан хүмүүс цомхотголоор юм уу ямар нэгэн байдлаар гарахлаар байгууллагаас олгодог ажилгүйдлийн тухайн тэтгэмж нь нэг өөр.

Хоёр дахь нь болохлоор нийгмийн даатгалын шимтгэлээ буюу ажилгүйдлийн шимтгэлээ төлөөд тэгээд ажилгүй болчихоод эргээд Нийгмийн даатгалын сангаас энэ ажилгүйдлийн тэтгэмжээ авч чадахгүй хэсэг бүлэг хүмүүс байх шиг байна. Тэгээд энэ зүгээр өргөдөл өгчхөөд шууд тэр дор нь орохгүй байна гэж гомдол гаргаад байна уу эс үгүй бол Ажилгүйдлийн даатгалын сан маань хоосорчхоод байна уу? Юунаас болж энэ төлбөрөө авч чадахгүй байна вэ гэдэг ийм асуултад хариулж өгөхийг хүсье.

Б.Найдалаа: Аубакир сайд.

Т.Аубакир: Тийм, 2025 онд Ажилгүйдлийн тэтгэмжийн санг 162 тэрбум төгрөгөөр төсөвлөсөн. Сүүлийн 2 сарын ажилгүйдлийн тэтгэмжийг олгох бас боломжгүй болоод байгаа.

1 дүгээрт, уул уурхай дээр ажиллаж байгаа тээврийн жолооч нар маш олноор ажлаас цомхотгосон. Жишээлбэл, Ховд аймгийн Хөшөөтийн уурхайгаас 1200 жолооч. Үүн дээр нэмэх нь сая төрөөс хийсэн 9 хувийн цомхотголтой холбоотой 14400 төрийн албан хаагчийг цомхотгох байснаас 7 мянга гаран төрийн албан хаагчийг цомхотгосон. Эдгээр иргэдийн ажилгүйдлийн тэтгэмжийг олгосонтой холбоотой сая 25 онд төсөвлөсөн төсөв маань хүрэхгүй нөхцөл байдалд хүрсэн.

26 онд Ажилгүйдлийн тэтгэмжийн санг бид нар 190 тэрбум төгрөгөөр 26 оны улсын төсөвт саналаа хүргүүлээд батлуулсан байгаа. Мөн ажилгүйдлийн тэтгэмжийг авдаг энэ журмаа бид нар бас эргэж харах зайлшгүй шаардлага бий болж байгаа юм. Нөгөө талдаа бас сангаас зориудаар гэх юм уу, эсвэл хууль бусаар байдаг юм уу тэтгэмж авах иргэдийн тоо бас нэмэгдсэн. Яг ний нуугүй л хэлэхгүй бол бид нар бас нууж хаагаад байх шаардлага байхгүй. Тийм учраас бид нар эргээд энэ журмаа эргэж харах. Одоо ажилд орсон иргэн 6 сар ажиллаад л амралтаа бодуулах эрх үүсчхэж байгаа. 9 сар ажиллаад л нийгмийн даатгалын шимтгэлээ төлөөд л Ажилгүйдлийн сангаас ажилгүйдлийн тэтгэмж авах бололцоотой болчихсон. Энэ маань зөвхөн энэ ажлын байр тогтворгүй болсонтой холбоод тогтворгүй болж байгаа энэ нөхцөл байдал зөвхөн манай улсын хэмжээнд тулгараад байгаа асуудал бас биш Олон улсын валютын сангаас бас сануулж зөвлөмж хүргүүлж байгаа.

Одоо залуучууд нэг байрандаа тэтгэвэрт гартлаа ажиллах, нэг байрандаа он удаан жил ажиллах ийм залуучуудын сүүлийн үед энэ сонирхол нь ийм болчихсон. Нэг ажлаас нөгөө ажил руу шилжих, зайнаас ажиллах гэх зэрэг олон ажлыг, 2, 3 ажлыг зэрэг хийх зэрэгтэй холбоотой ажлын байр тогтворгүй болсонтой дэлхийн нийтэд ийм проблемууд тулгарч байгаа.

Тийм учраас эдгээр иргэдийн тэр сонирхолд тохирсон ажлын байруудаа бий болгооч гэсэн зөвлөмжийг хүртэл Олон улсын валютын сангаас өгдөг. Ингээд 9 сар ажиллаад Ажилгүйдлийн тэтгэмжийн сангаас тэтгэмж авах нөхцөл бүрдчихэж байна гэдэг нь нэг ажлын байрандаа тогтвортой ажиллах тэр сонирхлыг бас бууруулж байгаа юм. Тийм учраас бид нар он гараад энэ дүрэм, хуулиудаа бас эргэж харах ийм зайлшгүй цаг үеийн нөхцөл байдал үүсчхээд байгаа юм. Тийм учраас Ариунзаяа гишүүн ээ энэ жилийн яг ажилгүйдлийн энэ тэтгэмжийн авах боломж яг сүүлийн 2 сар одоо боломжгүй болсон. Бид нар он гараад дахиж нөхөж өгөх асуудлыг ярьж байгаа. Зарим асуултад манай яамны хүмүүс хариулаарай.

Б.Найдалаа: Хариулт хангалттай юу Ариунзаяа гишүүн? Микрофон 4.

Б.Батжаргал: Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Нийгмийн даатгалын ерөнхий газар Батжаргал. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн хувьд ажил олгогч зөвхөн хариуцаж төлдөг. Ажлын байрны эрсдэлээс хамаараад 0.5, 1.5, 2.5 гэсэн ийм 3 шатлалаар шатлалт хувь хэмжээгээр төлдөг.

2025 оны нийгмийн даатгалын сангийн энэ 2025 оны төсвийн тухай хуулиар Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн орлогыг 272.2 тэрбум төгрөг, зарлагыг 66.6 тэрбум төгрөгөөр ингэж баталсан. Энэ орлогын төлөвлөгөө биелэлттэй гарч байгаа. 2026 оны нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай хуулиар орлогыг 426.3 тэрбум төгрөг, зарлагыг 70.8 тэрбум төгрөгөөр баталсан байгаа. Баярлалаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Ариунзаяа гишүүн хариулт болсон гэж үзэх үү, тодруулах уу? Ариунзаяа гишүүн тодруулж асууна.

А.Ариунзаяа: Яах вэ нөгөө батлагдсан зарлагынхаа хязгаарт л барьж өгөх ёстой тэтгэвэр, тэтгэмжээ өгөхгүй л байгаа юм байна шүү дээ тийм үү гэж л ойлголоо. Тэгэхээр өнөөдөр Төрийн сангийн асуудал ч гэсэн Төрийн сан үлдэгдэлтэй мөртөөсөө бас өгөх ёстой цалингийн урамшуулал, тэтгэвэр, тэтгэмжээ ч гэсэн бас өгөхгүй орлого байхгүй байгаа учраас зарлага бас гаргаж болохгүй байгаад байна. Хоорондын тэнцэл нь батлагдсан тэнцэлтэй нийцэхгүй байна гэж иргэдийг хохироогоод байгаа асуудлыг бас эргэж харах шаардлагатай юм уу л гэж хараад байна.

Ажилгүйдлийн тэтгэмжтэй холбоотой Нийгмийн даатгалын сангаас олгогддог тэтгэмжтэй холбоотой өөрчлөлтийг хуулиар л хийх ёстой болов уу гэж ойлгож байгаа. Тэгэхээр нийгмийн даатгалын багц хуулиа яаралтай оруулж ирнэ үү л гэж хүсье дээ.

Б.Найдалаа: Баярлалаа. Үг хэллээ. Эрдэнэбат гишүүн асуулт асуух гишүүнд нэмээдхээрэй. Саранчулуун гишүүн асуулт асууна.

О.Саранчулуун: Ганц л юм асуучихъя яг энэ холбогдох хүмүүс ирсэн юм чинь. Эрүүл мэндийн мэдээлэл буюу осол, мэргэжлийн өвчний талаарх мэдээлэл, нийгмийн даатгал, хөдөлмөрийн байгууллагын мэдээллийн ийм интеграци гэдэг юм уу даа тийм зүйл хэзээ болох вэ? Энэ дээр ер нь төлөвлөгөө нь яг яаж явж байгаа талаар тодруулах хүсэлтэй байна л даа. Яагаад гэхлээр одоо хөгжлийн бэрхшээлтэй болсон хүмүүсийг хөдөлмөрийн чадвар алдсан гэдэг ийм хувь гарч байгаа.

Тэгэхдээ хөдөлмөрийн чадвар алдсан хувийг нь эмч нар бүрдсэн эмнэлэг, хөдөлмөрийн магадлал комиссынхон гаргаж байгаа. Тэгэхээр ер нь олон хүмүүс энэ хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажиллаад хөгжлийн бэрхшээлтэй болж байгаа боловч дандаа эрүүл мэндийнх нь ингээд хувь тогтоогоод яваад байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр яг та бүхний хувьд шилжилтийн ямар төлөвлөгөө байгаа гэдгийг бүүр сайн тодруулаад сонсож байгаад тэгээд эргээд дахиад асууя.

Б.Найдалаа: Хариулт микрофон 4.

Б.Батжаргал: Нийгмийн даатгалын байгууллага Нийгмийн даатгалын ерөнхий хуульд зааснаар даатгуулагч иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох ажлыг хийж гүйцэтгэдэг. Энэ хүрээнд Засгийн газраас энэ Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрмийг батлахдаа бас эрүүл мэндийн байгууллага болон энэ зөвлөл хоёрын хооронд мэдээлэл солилцох ажлыг эхлүүлчихсэн байгаа. Жаахан удаашралтай байгаа нь үнэн. Энэ нь яагаад гэвэл эрүүл мэндийн байгууллагууд олон төрлийн систем ашигладаг учраас бид нар бас интеграция жоохон удаан хийж байгаа нь үнэн. Гэхдээ Хур систем дээр буюу дата төв дээр

бид нар интеграци хийх үндсэн схемээ дуусгаад одоо эхний шатны туршилтуудаа хийгээд явж байгаа.

Яг өнөөдрийн байдлаар гэх юм бол гишүүний хэлдэг үнэн. Бид нар Ай Си Ди 10 ангиллаар Эрүүл мэндийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдын хамтарсан тушаалаар баталсан өвчний ангиллаар буюу 600 орчим оношны бүлгээр бид нар энэ хөдөлмөрийн чадвар алдалтыг магадалж тогтоож байгаа. Үүнээс 97 оношны бүлэг нь хугацаагүй дахиж ирж магадалдаггүй ийм оношны бүлэгтэй байгаа. Цаашид энэ Ай Си Эф-ийг энэ Ай Си Ди-тэй хослуулж хэрэглэх юм уу, эсвэл Ай Си Эф-ийг дангаар нь оруулж ирэх юм уу гэдэг энэ бодлогын шийдлээ үе шаттай хийж энэ хөдөлмөрийн чадвараа алдсан иргэдийг бас ажлын байраар хангах, эмчлэн эрүүлжүүлэх, буцаан ажлын байран дээр нь буцаан гаргах гэсэн энэ том зорилтыг бас хийх ажил зайлшгүй хийгдэх шаардлагатай гэж үзэж байна.

Б.Найдалаа: Саранчулуун гишүүн тодруулж асууна.

О.Саранчулуун: Яагаад өнөөдөр Ай Си Эф гэдэг зүйл Монгол улсад яригдаад бараг 20 жил болж байгаа вэ гэхээр яг энэнтэй холбоотой байхгүй юу. Тэгэхээр манайхан энэ дээр бас анхаарлаа хандуулаасай. Яагаад гэхээр өнөөдөр би жишээлбэл хөдөлмөрийн чадвараа, миний хөгжлийн бэрхшээлтэй хүний цэнхэр үнэмлэхийг харахаар би 69 хувь хөдөлмөрийн чадвараа алдсан хүн байхгүй юу. Би тэгэхдээ миний эрхэлж байгаа хөдөлмөр бол оюуны хөдөлмөр. Тэгэхдээ би 69 хувь биш би 100 хувь оюуны хөдөлмөр эрхлэх чадвартай байгаа учраас өнөөдөр энд бодлого, асуудал, судалгаа яриад явж байгаа. Тэгэхээр өнөөдөр хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлж байгаа энэ Монгол Улсад баримтлаад байгаа тодорхойлолт өөрөө олон мянган хүнийг ажилгүй болгож байгаа. Тодорхойлолт нь оновчтой биш учраас.

Тэгэхээр та бүхэн энэ дээрээ ингээд ажиллаж байна, ярьж байна гээд байгаад байхаас Ай Си Ти 10-тайгаа зууралдаж байх хооронд чинь Ай Си Ти 11 чинь гараад, 9-төөгөө зууралдаж байтал 10 нь гараад ингээд яваад байгаа байхгүй юу. Энэ дээр ийм хурдацтай ийм салбар дундын харилцаагаа ер нь явуулах хэрэгтэй байгаа учраас л би тодруулаад байгаа. Тэгэхээр яг бодитой төсөл

Б.Найдалаа: Минутаа нэмж аваад нэгмөсөн тодруулж асуух юм уу? Саранчулуун гишүүн 2 дахь тодруулга нь юм байна.

О.Саранчулуун: Тэгэхээр би яг бодитой төсөл ярих гээд байна. Бодитой энэ дээр чинь ажлын хэсэг байна уу? Яг энэ дээр чинь анхаарч байгаа ямар нэгж байна энэ Засгийн газрын энэ холбогдох бүтэц дээр? Бүтэн жил ингээд 3 яамны дунд зууралдаж зууралдаж манай ажлын хэсэг сүүлдээ ДЭМБ-тай хамтраад бүр семинар хийсэн шүү дээ. Тэгээд та нараас хүмүүс дуудаж оролцуулсан тээ? Тэгэхээр танай дээр яг ямар бүтэц энийг хариуцаж байгаа юм? Тэгвэл хэдүүлээ энийгээ явуулмаар байгаа байхгүй юу. Яриад ингээд 26 оны төлөвлөгөөнд орсон уу үгүй юу гээд. Гэр бүлийн яаман дээр Ай Си Эф-ээр үнэлэх гэдэг зүйл орсон. Яг энэ мэргэжлээс шалтгаалах өвчний ангилал болон эрүүл мэнд, өвчний оношны бүлгийн асуудал дээр ажлын хэсэг гарсан уу үгүй юү гэдэг дээр тэр нь Ай Си Эф-тэй холбоотой зүйл байна уу үгүй юү гэдгээр би одоогоор мэдээлэл аваагүй байгаа болохоор тодруулж байгаа юм.

Б.Найдалаа: Хариулт 4 номер.

Б.Батжаргал: Тийм. Гишүүний асуултад хариулъя. Нийгмийн даатгалын ерөнхий газар Батжаргал. Гишүүний яг асууж байгаа асуултаар Ай Си Эф дээр яг нэг яам дангаараа хийхэд энэ үнэхээр бас юугүй бас нэлээн тийм хэцүү ажил гэж хараад байгаа юм байна лээ. Тэгээд Эрүүл мэндийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, шаардлагатай бүх агентлагууд орсон ажлын хэсэг яаман дээр байгуулагдаад явж байгаа. Тэгээд Төрийн нарийн бичгийн дарга бас танд тусгайлан бас мэдээлэл өгөх болов уу гэж бодож байна.

Ай Си Эф руу бас яаралтай орохгүй бол одоо энэ Ай Си Ди 10-аар хөдөлмөрийн чадвар алдалтаа тогтоолгосон боловч бас ажил хөдөлмөр эрхлээд байгаа нь бас нэлээдгүй олон мянган хүмүүс бас байгаа. Одоогийн мөрдөж байгаа хуулиар бид нар тэтгэврийг нь огт зогсоодоггүй. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, холбогдох конвенцод зааснаар ажил хөдөлмөр эрхэлж байгаа бол цалингаа ч авна. Нийгмийн даатгалын сангаас буюу эсвэл халамжийн сангаас авч байгаа тэтгэврээ ч авна гэсэн энэ зарчим бас явж байгаа юм байна лээ. Баярлалаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Дэгийн дагуу гишүүд 3 минут асуулт асуух ёстой. Тодруулга байхгүй. Сая хариулт болон түрүүний асуудалтай холбоотой Саранчулуун гишүүнд нэмж тодруулга өглөө. Алтаншагай гишүүн 3 минут асуулт тавина.

Н.Алтаншагай: 2 тодруулах зүйл байна. Гадаадад ажиллаж байгаад үйлдвэрлэлийн осол, гэмтэлд орсон хүмүүс энэ Даатгалын сангаас энэ асуудал нь шийдэгддэг үү? 1 дүгээрт.

2 дугаарт, энэ үйлдвэрлэлийн ослын улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хэмжээг тогтоодог. Энэ яг ямар байгууллагууд дээр тогтоогдож байгаа вэ? Би бодохдоо нийгмийн даатгал болон энэ тухайн шатын эрүүл мэндийн байгууллагуудын халамжийн хамтарсан хурлаар шийдээд байх шиг байдаг. Энэ дээр бас маргаантай, гомдолтой хүмүүс байдаг. Зүй ёсоор бас яг тэр хувь, хэмжээгээ тогтоолгож чадсангүй гэсэн хүмүүс байдаг. Одоо орох ёсгүй хүмүүс орчихсон байна ч гэсэн ийм маргаан гардаг. Тэгэхээр энэ дээр тодорхой мэдээллийг өгч. Жилээс жилд энд ер нь өсөөд байгаа л хандлагатай харагдаж байна энэ сайдын хийсэн мэдээлэл дээрээс харахад.

Б.Найдалаа: Хариулт микрофон 4.

Б.Батжаргал: Гишүүний асуултад хариулъя. Нийгмийн даатгалын ерөнхий газар Батжаргал. Гадаадад ажиллаж байгаа Монгол иргэдийн хувьд үйлдвэрлэлийн осолд орсон тохиолдолд тухайн улсын хууль тогтоомжоор шийдэгдэх эхний конвенцын заалттай. Гэхдээ бид нар одоо гадаадад байгаа Монголчуудаа хамгаалахын тулд нийгмийн хамгааллын хэлэлцээр байгуулж ажиллаж байгаа. Одоо нийт 6 улстай бид нар нийгмийн хамгааллын хэлэлцээртэй. Энэ хэлэлцээрт үйлдвэрлэлийн ослын холбогдох хамгаалалтыг нь зааж өгсөн байгаа тохиолдолд бид нар Монголд ирсэн тохиолдолд энэ тухайн улсад тогтоогдсон үйлдвэрлэлийн ослын улмаас тогтоосон тэтгэврийг Монгол руу экспортолдог ийм зохицуулалтыг нь бид нар бас хэлэлцээртээ шигтгэж өгдөг. Жишээлбэл, Унгар улсын хэлэлцээр байна. Польш улсын хэлэлцээр байна. Чехийн хэлэлцээр дээр энэ заалт бас тусгагдаж явдаг.

Монголчууд, Монгол иргэд гадаадад байхдаа Монголынхоо нийгмийн даатгалд даатгуулж бас болдог сайн дурын даатгал хэлбэрээр. Энэ даатгал дотор тэтгэврийн даатгал, тэтгэмжийн даатгал, ослын даатгал гэсэн 3 даатгал үндсэн хамгаалалт болдог. Тэгээд энэ даатгалтай байгаа тохиолдолд Монголд Үйлдвэрлэлийн ослын даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмжээ авах эрх нь нээлттэй байдаг.

Үйлдвэрлэлийн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан иргэдийн хөдөлмөрийн чадварыг тогтоох ажлыг та бас зөв хэллээ Нийгмийн даатгалын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөл гээд орон тооны бус зөвлөл ажилладаг. Энэ зөвлөл дотор эмч нар орно хамгийн гол бүрэлдэхүүн. Хөдөлмөр, халамж үйлчилгээний ажилтнууд орно. Нийгмийн даатгалын байгууллагын ажилтнууд, магадлагч эмч, хараат бус гишүүд буюу ажил олгогч болон даатгуулагчийн төлөөлөл орж ажилладаг. Орж чадахгүй байгаа хүмүүс дээр оруулдаггүй ашиг сонирхлын зөрчил гаргадаг гэсэн ийм зөрчил, бас гомдлууд бас ирдэг. Бид нар нээлттэй утас тогтмол ажиллуулж байгаа. Ийм зөрчил гарвал бид нар газар дээр нь шалгаад шаардлагатай тохиолдолд бид нар өнгөрсөн онд АТГ-тай бас бид нар хамтарч ажиллаж нэлээдгүй зөрчлийн ард гарсан байгаа. Тэгээд энэ ажлын үр дүнд нийт хөдөлмөрийн чадвар алдсан хүмүүсийн тоо сүүлийн 5 жилийн хугацаанд 9 мянгаар буурсан ийм үр дүнтэй бас байгаа. Баярлалаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Уянга гишүүн.

Б.Уянга: Энэ өдрийн мэнд хүргэе. Өнөөдөр Байнгын хорооны гишүүддээ энэ сантай холбоотой мэдээллийг сонсож байгаад бас талархал илэрхийлье. Түрүүн яамнаас мэдээллээ сайд өөрөө танилцуулаад холбогдох ажлын алба нь ирсэн байна. Тэгээд энэ Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын санг өнөөдөр ярих болсон шалтгаан нь зүгээр бид нар ажил, хөдөлмөрөө эрхэлж байгаад бэртдэг байх, бэртлээ гэж бодоход дараа нь яах вэ, эсвэл бэртэхгүй, гэмтэхгүй байх дээр нь юу хийж болох вэ гэдэг дээр нь тийм бодлого гаргаад, төлөвлөгөө гаргаад, мэдээллийг ер нь сонсьё гэж л анх яам руу энэ саналыг хүргүүлээд холбогдох мэдээллийг яамнаас авсан байгаа.

Тэгээд энэ Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын санд эрчим хүчний салбарт ажиллаж байгаа хөдөлмөр эрхлэгчид, барилгын салбарт ажиллаж байгаа хөдөлмөр эрхлэгчид, тэгээд уул уурхайн салбарт ажиллаж байгаа хөдөлмөр эрхлэгчид нийгмийн даатгалд өгч байгаа тэр мөнгөнийхөө түрүүн бас ажлын хэсгээс танилцуулсан 0.5, 1.5, 2.5 хувийг ингээд суулгадаг байгаа юм билээ. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмжийн төлбөрийн тухай гээд хуульд болохоор 2017 оноос 2024 оны хооронд урьдчилсан сэргийлэх ажилд нь 1 хувь, тухайн жилийнхээ орж ирэх мөнгөний 1 хувийг зарцуулна гээд 24 оноос 2 хувь болгосон юм билээ. Тэгээд энэ бас яамнаас, Засгийн газраас яг энэ хуульд нь урьдчилсан сэргийлэх ажилд нь мөнгө тавьдаг болсон энэ зохицуулалт нь суусанд бас талархалтай хүлээж авч байгаа юм.

Тэгэхдээ 2017 оноос хойш юу хийсэн юм бэ гэдгийг нь л сонирхож мэдэхийг хүсэж, 2026 оны төсөвт яг энэ 2 хувьд нь хүргээд урьдчилсан сэргийлэх ажилд нь мөнгө суулгасны хувьд хийсэн ажлыг нь давтахгүй юм сан гэдэг дээр энэ мэдээллийг сонсож байгаа. Тэгээд энэ 2 хувьд хүргээд 2026 оны төсөвт урьдчилсан сэргийлэх зардалд нь хүргэхийн төлөө хамтарч Эрдэнэбат гишүүнтэй,

Зулпхар гишүүнтэй, Рэгдэл гишүүнтэй дандаа энэ Байнгын хорооны гишүүдтэй хамтарч ажилласан.

Ингээд яамнаас холбогдох тайлан ирсэн. 2017 оноос урьдчилан сэргийлэх ажил буюу ажлын байран дээрээ гэмтэхгүй юм шүү, бэртэхгүй юм шүү гэдэг дээр мөнгө тавьж эхэлсэн байгаа юм. Гэхдээ 2023 оноос хойших ажлынх нь тайлан ирсэн байгаа юм. Одоо мэдээлэл нь. Энэ яагаад тэгж байгаа юм бол оо? 2017 оноос 2022 он хүртэл ямар ажлууд хийгдсэн юм бол? Хийгдсэн ажлуудыг харахаар ер нь энэ хуультай холбоотой үйлдвэрлэлийн осол гэж юу юм, мэргэжлээс шалтгаалах өвчлөл гэж юу юм гээд сургалт явуулдаг юм шиг байгаа юм. 2025 онд 235 мянган хүнд хүрсэн гээд байгаа юм. Тэгэхээр ер нь хэр үр дүнтэй байсан юм бол? Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Батжаргал дарга саяхан томилогдсон. Нэлээн “progressive” хандлагатайгаар 2026 оны төсөв дээр ажиллаж байх шиг байна лээ. Гэхдээ цаашдаа ямар ажлуудыг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа вэ?

Б.Найдалаа: Хариулт микрофон 4.

Б.Батжаргал: Гишүүний асуултад хариулъя. Нийгмийн даатгалын ерөнхий газар Батжаргал. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйл дээр үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг юу юу авахыг нь тодорхой заагаад өгчихсөн байгаа.

13.1 дээр үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын үйл ажиллагаа хууль тогтоомжтой холбоотой мэдээлэл, зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа.

13.1.2 дээр урьдчилан сэргийлэх талаар даатгуулагч, ажил олгогчид зориулсан хөдөлмөр, аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт.

13.1.3 дээр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн шинэ техник технологи, инновацад нэвтрүүлсэн ажил олгогчийн шилдэг туршлага, ололт амжилтыг олон нийтэд сурталчлах.

13.1.4.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний чиглэлээр хийх тандан судалгаа, эрсдэлийн болон хяналт шинжилгээ, үнэлгээ гэсэн ийм 4 үндсэн чиглэлээр бид нар хуульд заасан нөгөө төсвийнхөө зарцуулдаг энэ 4 чиглэл рүү явуулна.

Гэхдээ бас нэг зүйл дээр шүүмжлэлтэй байгаа нь үнэн. Тэр юу вэ гэхээр урьд нь ийм жижиг жижиг арга хэмжээг бас ийм салангид байдлаар авдаг байсныг одоо энэ жилээс, дараа жилээс болиулъя гэж байгаа. Нэлээн тийм даацтай, хүмүүст хүрэхүйц, ажил олгогч нарт хүрэхүйц ийм ажлуудыг хийхгүй бол одоо ингээд тендерийн Худалдан авах ажиллагааны тухай хуулиар бүх ажлууд явагдаж байгаа энэ оноос эхлээд. Дараа жил адилхан явуулна. Гэхдээ бүсчлээд юм уу эсвэл тодорхой хамгийн эрсдэл өндөртэй салбар руу, хамгийн эрсдэл өндөртэй 3 салбар руу гэдэг ч юм уу энэ журам нь бас яг тэгж гарсан байж байгаа. Тэгээд энэ журмынхаа хүрээнд хамгийн эрсдэл өндөртэй, эрсдэл учирч болохуйц салбараа тодорхойлоод тэр рүү бас чиглэсэн, цэглэсэн ажлуудыг нэлээд үр дүнтэй хийе гэсэн ийм бодлогыг л барьж ажиллаж байгаа. Баярлалаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Ганмаа гишүүнийг асуулт асуух гишүүний нэрд нэмье. Эрдэнэбат гишүүн асуулт асууна. Эрдэнэбат гишүүн байхгүй байна. Ганмаа гишүүний микрофоныг нээе.

Д.Ганмаа: Сайн байцгаана уу? Цөөхөн хэдхэн асуулт. Их хэрэгтэй юм ярьцгааж байна бид нар. Энэ 1 дүгээрт энэ Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн нийт зардлын хэдэн хувийг урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хэрэглэдэг вэ, зарцуулдаг вэ? Энэ талаар ярьсан байж магадгүй. Жишээлбэл, энэ олон улсын нөгөө хөдөлмөрийн байгууллага гэдэг билүү Ай Эл Эф гээд байдаг шүү дээ. Тэрний зөвлөмж юм уу олон улсын дундажтай харьцуулахад манайх хэр зэрэг мөнгө зарцуулдаг юм бол гэдэг 1 дүгээр асуулт.

Хоёр дахь нь энэ эрүүл мэндийн салбараас хүн байна уу үгүй юү, тэгэхдээ анхан шатын түвшний оролцоо хэр зэрэг байдаг юм бол гэсэн асуулт байгаа. Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлыг сайжруулахад анхан шатын эрүүл мэндийн байгууллага, мэргэжлийн эмч нарын оролцоог хэрхэн хангаж ажилладаг вэ гэсэн асуулт байгаа. Тэгээд мэргэжлээс шалтгаалсан өвчлөл гэж байгаа шүү дээ. Тэр өвчлөлийн эрт илрүүлэг ч юм уу, урьдчилан сэргийлэлт, тандалтын тогтолцоотой холбоотой бас ямаршуу систем явагддаг юм бол? Ийм 3 асуулт л байна.

Б.Найдалаа: 3 асуулт микрофон 4.

Б.Батжаргал: Гишүүний асуултад хариулъя. Ослын даатгалын хуульд зааснаар урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал тухайн жилийн нийт шимтгэлийн орлогын 2 хувиас багагүй байхаар ийм заалттай. Энэ 2026 оны нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай хуульд бас манай Уянга гишүүн, Эрдэнэбат гишүүний санаачилгаар энэ дүн анх удаагаа бас 5.1 хувьд хүрч нэмэгдсэн байгаа. Нийт 16.4 тэрбум төгрөг энэ дараа жилийн төсөв дээр анх удаагаа ингэж суусан байна.

Анхан шатын хувьд энэ оролцооны хувьд болохоор ер нь энэ Үйлдвэрлэлийн ослын даатгалын тухай хуулийн нэг зорилго нь л энэ урьдчилан сэргийлэх байгаа. Энэ маш чухал зорилт. Анхан шатын хувьд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль гээд бас тусдаа нэг том хууль бий. Энэ хуулийн хүрээнд бас ажил олгогч өөрөө бас энэ ХАБ-ын сургалтын асуудал, урьдчилан сэргийлэх асуудлыг хариуцаж ажиллах ёстой. Энэ зорилгоор бас тодорхой хэмжээний зардал гаргах үүргийг бас ажил олгогч хүлээсэн байдаг байна.

МШӨ-гийн хувьд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн захирал Нарансүх захирал хариулах байх гэж бодож байна.

Б.Найдалаа: Микрофон 6.

Д.Нарансүх: Манай Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан ийм төрийн үйлчилгээний байгууллага. Манай байгууллага дээр мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын нарийн мэргэжлийн эмнэлэг үйл ажиллагаа явуулдаг. 1967 онд байгуулагдсан. Манай улсад 1972 оноос 2025 оны хооронд нийт 10409 хүн мэргэжлээс шалтгаалсан

өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан байдаг. Эдгээр хүмүүсийн маань 51 орчим хувь нь тоостой холбоотой, уушги тоосжих өвчин бусад амьсгалын замын эрхтний өвчлөлөөр өвчилсөн байдаг.

Ер нь манай улсын хувьд энэ мэргэжлээс шалтгаалсан өвчний оношилгоо, хөдөлмөрийн чадвар алдалтыг бүртгэдэг ийм тогтолцоо маань Нийгмийн даатгалын ерөнхий газрын Эрүүл мэндийн магадлалын зөвлөлтэй хамтарч манай эмнэлэг дээр хэрэгждэг. Энэ оноос мэргэжлээс шалтгаалах өвчнийг бүртгэж мэдээлэх журмыг.../минут дуусав./

Б.Найдалаа: Баярлалаа. Гишүүд асуулт тавьж, хариулт авч дууслаа.

Дэгийн тухай хуульд заасны дагуу асуулга тавьсан гишүүн 5 минутаас илүүгүй хугацаанд үг хэлэх, асуулгатай холбоотой өөр асуулт асуух боломж байгаа. Уянга гишүүн үг хэлэх үү? Уянга гишүүний микрофоныг нээе.

Б.Уянга: Баярлалаа. Гол яг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдаас асуулгын хариу болгож ирсэн 2 тоон мэдээллийг дурдах хэрэгтэй гэж бодож байна. Манай энэ Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүд бас сонсоод цааш цаашдаа та хэд маань хэрвээ ажлын хэсэг байгуулаад нэлээн гүнд нь орж ажиллах хэрэгтэй болбол мөрдлөг болгоод, тоогоо бууруулах дээр нь ажиллаж магадгүй юм.

Бид нар яг өнөөдөр ярьж байгаа юм нь ажил, хөдөлмөрөө эрхэлж байхдаа яаж хөдөлмөр эрхлэгчдээ гэмтээхгүй вэ, бэртээхгүй вэ л гэдэг тал дээр л уул нь ярья гэж бодсон. Тэгээд 2023 оноос хойших яамнаас хэрэгжүүлж байгаа ажлуудыг сайдаас мэдээлэл байдлаар ирүүлсэн. Эндээс 2 тоо заавал бүгдээрээ мэдээд авчихъя гэж бодож байгаа. Мэргэжлээс шалтгаалаад өвчинтэй болсон, түүнээсээ болоод хөдөлмөрийн чадвар алдалттай болсон хүмүүс 3.8 хувь буурсан юм билээ. Тэгэхээр 2017 оноос хойш энэ яамны бодлогын дагуу авч хэрэгжүүлж байгаа ажлын үр дүн нь мэргэжлээсээ шалтгаалаад өвдөж байгаа иргэдийн тоо буурсан. Гэхдээ үйлдвэрлэлийн ослын улмаас буюу ажил, хөдөлмөрөө эрхэлж эрхэлж байхдаа гэмтэж, бэртэж байгаа тэр байдлаасаа болоод хөдөлмөрийн чадвар алдалт нь 2.1 хувиар харин өсчихсөн юм билээ. Тэгэхээр энэ өсөхгүйгээр л хамаг юмаа л бууруулж байвал их зүгээр байгаад байдаг.

Тэгэхээр 2026 ондоо яг энэ хуулийн заалтын дагуу 2026 онд яг энэ санд төвлөрөх мөнгөний 2 хувийг нь урьдчилсан сэргийлэх ажилд нь зарцуулна гээд Улсын Их Хурлаас батлаад өгчихсөн байгаа учраас түрүүн Батжаргал даргын хэлдгээр магадгүй яг бүсчлээд бүс бүсүүд дээрээ энэ эрчим хүчний салбарынхан, барилгын салбарынхан, уул уурхайн салбарынхны яг ажлын байран дээрээ бэртэхгүй, гэмтэхгүй байх дээр нь ямар ажлууд хийх юм, эсвэл яг тэр тээврийн том том замууд ч юм уу үнэхээр осол их гараад байдаг тэр тоонууд нь харагдаж байгаа газартаа бас юу хийх вэ гэдгийг сайн төлөвлөөд одоо л яг төлөвлөгөөндөө суулгадаг цаг нь гэж ойлгосон. Тэгэхээр та хэд маань нэлээн тийм шинэлэг байдлаар сайн төлөвлөгөөтэй ажиллахыг хүсье.

Ер нь асуултууддаа хариулт авсан. Гэхдээ 2017 оноос хойш урьдчилан сэргийлэх ажилд мөнгө суулгадаг болсон юм чинь уул нь 2017 оноосоо хойш бид нар ийм юм хийсэн юм гэдгээр 2022 он хүртэлх ажлаа товч мэдээлбэл бас хэрэгтэй байж магадгүй. 2023 оноос хойшхыг харсан. 24, 25 дандаа сургалтын ажлууд хийчихсэн байсан. Тэгэхээр 17-гоос 22 оны хооронд хийгдсэн ажлуудыг

үлдсэн хугацаанд товчхон дүгнээд хэлбэл бас Байнгын хорооны гишүүдэд хэрэгтэй байх аа. Баярлалаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Уянга гишүүнээс Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдад хандсан асуулгын хариуг хэлэлцэж дууслаа.

Түрүүн гаргасан тогтоолтой холбогдуулан Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төслийг бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Наранцэцэгийн Алтаншагай гишүүнийг өөрийнх нь хүсэлтээр нэмэх юм шүү.

Өнөөдрийн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал хэлэлцэж дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Баярлалаа. Идэвхтэй оролцсон гишүүддээ маш их баярлалаа.

17.27 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР